ТУСГААР ТОГТНОЛ

№4(52)
2020

Үндэсний аюулгүй байдал, тагнуул судлалын эрдэм шинжилгээ, судалгаа, онол, аргазүйн сэтгүүл

Жилд дөрвөн дугаар гарна

Энэ дугаарыг ТЕГ-ын Тусгай архиваас эрхлэн гаргав.

ТЕГ-ын Тусгай архивын баримтыг нийтийн хүртээл болгох, тагнуулын байгууллагын түүхэн замналыг судлах сурталчлах зорилготой болно.

ЭНЭ ДУГААРТ

ТҮҮХ СУДАЛГАА

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТАД ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА 3
Б.Эрдэнэбилэг

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ҮЕИЙН СУРТАЛ-УХУУЛГЫН
АЖИЛ БА ӨВӨР МОНГОЛ АРД ИРГЭДИЙН ОРОЛЦОО 10
На.Батболд

АРХИВЫН САН ХӨМРӨГӨӨС

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨВӨР МОНГОЛЫН
АРД ТҮМЭНД ТАРААЖ БАЙСАН УХУУЛАХ ХУУДСУУД 17
С.Цэрэндэжид

ХЯЗГААРЫН 7 ДУГААР ОТРЯДЫН УЧАСТОК ДЭЭР
ТУСГАЙ СУМАН БАЙГУУЛАХ ТУХАЙ 20
Д.Наранцэцэг

БНМАУ-ЫН МАРШАЛ Х.ЧОЙБАЛСАНГИЙН 1945 ОНЫ
8 ДУГААР САРЫН 10-НД РАДИОГООР НИЙТ
АРД ИРГЭДЭД ХАНДАЖ ХЭЛСЭН ҮГ 23
На.Батболд

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН АХМАД ДАЙЧДЫН ДУРДАТГАЛ

МАНЖУУР, ХАЙЛААРЫН ЧИГЛЭЛИЙН ТУСГАЙ
ГРУППИЙН ГИШҮҮН Г.НАМХАЙДАГВЫН ДУРДАТГАЛ 29
Д.Отгонцэцэг

БАЙШИНТЫН 7 ДУГААР МОРЬТ ДИВИЗИЙН
2 ДУГААР ХОРООНООС ОРОЛЦСОН ТУСГАЙ
ТӨЛӨӨЛӨГЧ Я.САНЖЖАВЫН ДУРДАТГАЛ 33
Д.Отгонцэцэг

МАТАДЫН 22 ДУГААР МОРЬТ ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨГЧ
Т.ШАГДАРЫН ДУРДАТГАЛ 36
Д.Отгонцэцэг

24 ДҮГЭЭР ОТРЯДЫН ТУСГАЙ ГРУППИЙН ОРЛОГЧ
ДАРГА Х.ХАСБАЗАРЫН ДУРДАТГАЛ 40
Д.Отгонцэцэг

20 ДУГААР ОТРЯДЫН ТУСГАЙ АНГИЙН ДАРГА У.ХУВДАЙН ДУРДАТГАЛ . . . 43
Д.Отгонцэцэг

INDEPENDENCE

Research journal of national security, intelligence studies

CONTENTS

HISTORICAL RESEARCH

INTELLIGENCE AGENCY ROLE IN VICTORY OF SOVIET-JAPANESE WAR 3
B.Erdenebileg

PROPAGANDA DURING SOVIET-JAPANESE WAR AND CITIZENS PARTICIPATION OF INNER MONGOLIA 10
Na.Batbold

FROM THE ARCHIVAL STUDIES

PROPAGANDA BANNERS DISTRIBUTED TO PEOPLES OF INNER MONGOLIA FROM GOVERNMENT OF THE MONGOLIAN PEOPLE'S REPUBLIC 17
S.Tserendejid

ESTABLISHMENT OF SPECIAL BATALLION AT THE SEVENTH BORDER BRIGADE 20
D.Narantsetseg

SPEECH ON RADIO TO THE PEOPLE OF MONGOLIA BY M.P.R. MARSHAL CHOIBALSAN.KH ON 10 THE OF AUGUST 1945 23
Na.Batbold

MEMOIRES

MEMOIR OF NAMKHAIDAGVA.G WHO WAS THE MEMBER OF SPECIAL UNIT ON HAILAR AND MANZHOULI 29
D.Otgontsetseg

MEMOIR OF SPECIAL AGENT SANJJAV.YA WHO PARTICIPATED FROM THE 2ND SECTION OF 7TH CAVALIER DIVISION OF BAISHINT 33
D.Otgontsetseg

MEMOIR OF AGENT SHAGDAR.T, 22ND CAVALIER SECTION 36
D.Otgontsetseg

MEMOIR OF COMMANDER KHASBAZAR.KH, 24TH SPECIAL BATALLION 40
D.Otgontsetseg

MEMOIR OF COMMANDER KHUVDAI.U, SPECIAL UNIT 20TH BRIGADE 43
D.Otgontsetseg

ТҮҮХ СУДАЛГАА

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ЯЛАЛТАД ТАГНУУЛЫН БАЙГУУЛЛАГА

Доктор Б.Эрдэнэбилэг

Дэлхийн II дайныг төгсгөх асуудал нь Японы Ази дахь түрэмгийллийг таслан зогсоож чадах эсэхээс шууд хамааралтай байв.

1945 оны 5 дугаар сард Герман үг дуугүй бууж өгснөөр Европ тивд энх тайван байдал тогтсон боловч Японы зүгээс Подстамын тунхаглалын шаардлагыг үл хайхран “Европт цэрэг дайны байдал өөрчлөгдсөн ч манай эзэнт улсын байлдааны зорилгыг өөрчлөхгүй” гэж мэдэгдэн дайнд бэлтгэсэн хэвээр байв.

Энэхүү нөхцөл байдалд Ялтын Бага хурал дээр хэлэлцэж тохиролцсон ёсоор 1945 оны 8 дугаар сарын 9-нд Японы эсрэг дайн зарласан Зөвлөлт Засгийн газрын мэдэгдлийг БНМАУ дэмжиж байгаагаа илэрхийлж, Зөвлөлт-Монголын харилцан туслалцах гэрээгээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх, өөрийн орны аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс 8 дугаар сарын 10-нд Японд мөн дайн зарлажээ.

БНМАУ нь Японд дайн зарлахдаа түүний дарлалын эсрэг тэмцэж байсан Өвөр Монголын ард түмний тэмцэлд туслах зорилготойгоо хамтад нь илэрхийлсэн байна.

Ийнхүү Японы эсрэг дайнд Зөвлөлт-Монголын цэрэг, дайчидтай мөр зэрэгцэн Улсыг аюулаас хамгаалах байгууллага, түүний ажилтнууд оролцож, далд фронтод тулалдсан юм.

Япончуудаас Зөвлөлт, Монгол Улсын улс төр, эдийн засгийн байдал, батлан хамгаалах хүчин чадал, ялангуяа цохилт өгөх чиглэлийнхээ цэрэг, зэвсгийн тоо хэмжээ, байрлал, цэргийн нөөц, газар орны байдлыг тагнан туршиж, давших замынхаа аюулгүй байдлыг хангах явдал тэдний дайны бэлтгэлийн үндсэн хэсгийн нэг байв. Энэ зорилгоор манай улсын эсрэг тагнан турших төвийг Манжуур, Өвөр Монголын нутаг Хайлаар, Харбин, Жанчхүү хотуудад байгуулж, тэдгээрийн салбарыг Халуун рашаан, Нуухын сүм, Хандгайт, Вангийн сүм зэрэг газруудаар тагнуул, хорлон сүйтгэх байгууллагуудыг олноор байгуулан идэвхтэй ажиллагааг зохиож байв. Тухайлбал, 1945 оныг 1941 онтой харьцуулахад Японы

тагнуулын газар, хэлтэс, тасаг 2 дахин нэмэгдсэн байна.

Улсыг аюулаас хамгаалах байгууллага нь чөлөөлөх дайнд оролцохдоо улс орны болон цэрэг армийнаюулгүйбайдлыгхамгаалах, Өвөр Монголын чөлөөлөгдсөн нутгийн ард олны аюулгүй байдлыг хангах, төвхнүүлэхэд тусламж үзүүлэхийг гол зорилгоо болгосон бөгөөд энэхүү зорилгын үүднээс Улсыг аюулаас хамгаалах байгууллагын ажилтнууд нь Японы тагнуулын болон хорлон сүйтгэх байгууллагыг илрүүлэх, устгах, чөлөөлөгдсөн нутгийн ард түмний аж амьдралыг сэргээн босгох ажлыг зохион байгуулах, улсын чухал объектуудыг хамгаалах, фронт ар талыг холбосон харилцааны шугамыг хамгаалах, усан хангамжийг хяналтандаа авах, дайсагнасан ямарваа нэг үйлдлийг цаг тухайд нь илрүүлэн таслан зогсоох, Монголын оргодлуудыг илрүүлэн баривчлах, 1930-аад онд эх орноосоо дүрвэн гарагсдыг буцаан авчрах зэрэг үүргийг гүйцэтгэсэн юм.

Үүний зэрэгцээ чөлөөлөх дайны үед ДЯЯ-ны Армийн тусгай хэлтэс нь МАХЦ-ийн ангиудын аюулгүй байдлыг хангах, фронтын тэргүүн шугамаас ухрах буюу оргогчдыг баривчлах, ангийн дотор элдэв зөрчил гарвал зохицуулах, давшиж байгаа цэргийн ангиудын ар талд сөрөх тагнуулын ажил явуулах, анги, нэгтгэлүүдийн дэргэдэх тусгай тасгуудын сөрөх тагнуулын ажлыг удирдан зохицуулах, арми-ар талын холбоог бат найдвартай байлгах, цэргийн оргодол, Японы тагнуулыг илрүүлэх, өөрийн цэргийн дотор ухуулагчийн үүргийг гүйцэтгэх, Тусгай хэлтсийн ажилтнууд нь тус тусын хариуцсан ангийн хамт тулалдах үүрэгтэйгээр оролцжээ.

Чөлөөлөх дайны өдрүүдэд УАХБ-аас зохиосон өөр нэг чиглэлийн ажил нь чөлөөлөгдсөн нутгийн гүнд ажиллаж Япон, Гоминьданы тагнуулчид, эх орноосоо урвагчдыг илрүүлэн баривчлах, сураггүй болсон тагнуулч нараа эрэн сурвалжлах зэрэг үүрэгтэй тагнуулын дөрвөн группийг Өвөр Монгол, Манжуурт ажиллуулахаар шийдвэрлэж, дайн эхэлмэгц хилийн чанадад гарган ажиллуулсан байна. Үүнд:

ДЯЯ-ны тагнуулын хэрэг эрхэлсэн орлогч сайд бөгөөд IV газрын дарга Б.Дордог, яамны орлогч зөвлөх Н.С.Фридгут нарын удирдсан групп Өвөр Монголын Улаанцавын чуулганы төв Батхаалгын хийдийн чиглэлд ажиллажээ. Тэнд Япон тагнуулын хэлтэс, хорих газар байсны дээр Өвөр Монголын нэг хороо цэрэг байрладаг байв. Энэ хэсгийнхэн Монгол Улсыг талархдаг 10 гаруй хүнийг өөрийн талд татаж, 1942 онд эх орноосоо урваж Японы тагнуулд элсэгдсэн Дорж, Гоминьданы Хятадын тагнуул 9 хүнийг илрүүлэн баривчилж, Өвөр Монголын ард олонд ухуулга хийх, нутаг орныг нь төвхнүүлэх ажил зохиожээ.

ДЯЯ-ны сайд Б.Дүйнхэржав, Маршал Х.Чойбалсан, Ю.Цэдэнбал, ЗХУ-ын Элчин сайд И.А.Иванов нар

ДЯЯ-ны Хязгаарын ба Дотоодын цэргийн хэрэг эрхлэх газрын V хэлтсийн дарга Д.Данзан, сургагч И.В.Вычков, төлөөлөгч Д.Жамъян, орчуулагч Цэвээнов, радист Лут-Очир, Сандагдорж нарын бүрэлдэхүүнтэй групп Шилийн голын чуулганы Баруун Сөнөд хошуунд ажилласан юм. Энэ хошууны төвд Японы тагнуулын салбар, Өвөр Монголын цэргийн анги, салбар байрлаж байв. Уг хэсгийнхэн манай улсын болон Өвөр Монголын ард олны эсрэг гэмт хэрэг үйлдсэн, түүнд оролцсон 1224 хүнийг илрүүлж баривчилжээ. Мөн Зүүн Сөнөд хошуунд ардчилсан байгуулал тогтоох, орон нутгийн ард олны зан байдлыг судлах, зэвсэгт дээрэмчдийн бүлгүүдээс нутгийн иргэдийг хамгаалах арга хэмжээг авчээ. Түүнчлэн дээрэмчдээс винтов, пулемёт 625, гранат сум хэрэгсэл 300 орчмыг олзолж, Хятадын чөлөөлөх армид шилжүүлэн өгсөн байна.

ДЯЯ-ны орлогч сайд бөгөөд Улсыг аюулаас сахиж хамгаалах газрын дарга Б.Дүйнхэржаваар удирдуулсан групп Шилийн голын чуулганы төв Бандид гэгээний хийдийн Долнуурын чиглэлд ажиллав. Тэд эх орноосоо урвасан, Японы тагнуулын даалгавраар Монгол Улсын эсрэг тагнан турших ажиллагаа явуулсан 143 хүнийг илрүүлэн баривчилж, Японы тагнуулын зарим салбарын нууц баримт бичгийг олзлон авчирчээ.

ДЯЯ-ны IV газар буюу тагнуулын газрын хэлтсийн дарга Ц.Даваажав, сургагч Г.А.Савельев нарын удирдсан групп Манжуурын Хайлаар хотын чиглэлд ажиллажээ. Тэд Шар нуга хэмээх газар орогнон нуугдсан японы 14 офицер болон Солон хошууны Шинэхэн сүмийн орчимд байсан зэвсэглэсэн япончуудыг устгах, олзлох арга хэмжээг амжилттай зохиож, японы хорлон сүйтгэх хоёр хэсгийг илрүүлэн бут цохиж, 20 гаруй тагнуулчдыг нь баривчилж, Японы цэрэг-тагнуулын байгууллагын нэлээд хэмжээний архивыг олзлон авчирсан нь дайны өмнөх болон дунд үед Монгол, Зөвлөлтийн эсрэг явуулж байсан Японы тагнуулын ажиллагааг нь илрүүлэхэд чухал ач холбогдол үзүүлж байжээ.

Монгол-Зөвлөлтийн арми Өвөр Монголын нутагт байлдааны ажиллагааг явуулж эхэлмэгц фронтын ар талын аюулгүй байдлыг хамгаалахын тулд хилийн 9, 12, 17, 20, 23, 24, 27, 31 дүгээр отрядуудаас Японы эзэмшлийн нутагт ажиллах хөдөлгөөнт отрядууд томилогдож, эдгээр нь Зөвлөлт-Монголын давшиж байгаа армийн ар талын аюулгүй байдлыг хангаж, цохилтоос нуугдан үлдсэн Японы зэвсэгт бүлгийг илрүүлэн устгах, орон нутгийн байгууллагыг сэргээн тохинуулахад туслах үндсэн үүрэгтэй оролцсон бөгөөд удирдах бүрэлдэхүүнд нь тусгай анги, V тасаг буюу тагнуулын тасгийн дарга, төлөөлөгчид оролцож, хорлон сүйтгэгчид, Халхын оргодол, эх орноосоо урвагчдыг илрүүлэн баривчлах үйл ажиллагааг амжилттай гүйцэтгэсэн юм. Тухайлбал, хилийн 9 дүгээр отрядын дарга Э.Халтарын удирдсан хөдөлгөөнт отряд нь 270-аад хүний бүрэлдэхүүнтэйгээр Өвөр Монголын Улаанцавын чуулганы Батхаалгын чиглэлээр улсын хилийг давж, Дархан бээл, Дунд гүн, Дөрвөд хошууны нутагт байлдааны үүрэг гүйцэтгэсэн байна.

Эдгээр хөдөлгөөнт отрядууд гадаадын цэргийн албан хаагчид, Японы тагнуул, хорлон сүйтгэгчид, тэднийг туслан дэмжигчид, эх орноосоо урвагч оргодлууд зэрэг 2000 орчим хүнийг баривчилж, цэрэг дайны хэрэгцээнд ашиглаж байсан 100 мянга гаруй толгой мал, олон тооны буу зэвсэг, сум, хүнс, эд хэрэгсэл, баримт бичгийг олзолсон юм.

Энэ үед ДЯЯ-ны сайд Б.Шагдаржав, ерөнхий зөвлөх С.П.Гриднев нар зарим ажилтнуудын хамт фронтын ар тал буюу дайсны эзэмшилд байсан газар нутгаар явж хэсэг, групп, отрядуудын ажиллагаатай танилцан удирдамж өгөх, тулгамдсан асуудлыг газар дээр нь шийдвэрлэх ажлыг хийхийн зэрэгцээ тэнд ажиллаж байсан Засгийн газрын бүрэн эрхт төлөөлөгч нартай уулзаж, нөхцөл байдлыг танилцуулах зэрэг арга хэмжээг авч байв.

Чөлөөлөх дайны өдрүүдэд зүүн, өмнө зүгийн хилийн аймгууд болох Дорнод, Сүхбаатар,

ДЯЯ-ны Тусгай группийнхэн Өвөр Монголын нутагт

Дорноговь дахь аюулаас хамгаалах хэлтсүүд фронтын ар талд зохиох гүйцэтгэх ажлын арга хэмжээнд идэвхтэй оролцож, үүргээ амжилттай биелүүлсэн байна. Тухайлбал: Дорнод, Сүхбаатар, Дорноговь аймгууд дахь хэлтэс нь тус тусын аймгийн нутгийн чиглэлээр хилийн цаана ажлын хэсэг зохион байгуулан ажилласан бөгөөд тэдгээрийг ардууд болон нам, эвлэл, сайн дурын морьт отрядын гишүүнээр бүрэлдүүлэн зохион байгуулж, гүйцэтгэх ажилтан нар удирдаж байв.

Дорноговь дахь хэлтсээс хилийн цаана ажиллах шилдэг тэргүүний 40 орчим хүнийг сонгон авч, тэдгээрийн уналга болон гүйцэтгэх хэсгийн хэрэгцээнд шаардагдах 300 гаруй агтыг худалдан авах буюу ардуудаас сайн дураараа тусалсныг ашиглаж, тасгийн дарга Дашзэвэг, төлөөлөгч Жамбал, Доёд, Ухнаа нарын зэрэг гүйцэтгэх ажилтнуудаар удирдуулан Зүүн Сөнөд, Дөрвөд хошуу, тэдгээрийн залгаа орон нутагт жижиг хэсгүүдийг томилон ажиллуулжээ. Уг хэсгүүд тус яамнаас томилогдсон удирдан зохион байгуулах ажлын хэсгүүдтэй харилцан ажиллагаатай, өөрийн ажлыг зохион байгуулж чадсанаар Монгол-Зөвлөлтийн армийн гол цохилтоос сугарч үлдсэн Японы тагнуул, хорлон сүйтгэгчид, эх орноос урвагчид, Япон болон Дэ вангийн цэргийн албан хаагчид, харуулын цагдаа зэрэг 50 гаруй этгээдийг илрүүлэн баривчилсан байна. Эдгээрийн дотор Шилийн

цагаан овоо, Нуруу хашаат, Дунд гүний хошуу, Дөхөмийн сүм зэрэгт байсан Японы тагнуулын байгууллагын 13 баривчилсан байна. Тэрчлэн винтов, гар буу 65, сум 2000 гаруй, мөн 2000 гаруй төгрөгийн мал болон бусад эд материалыг олзлон авчээ.

Дорнод аймгийн хэлтэс дайны эхэн үед тус аймгийн нутгаар дамжин гарсан сайн дурын морьт отрядад 500 гаруй хүнийг цуглуулан өгч, тэдний хэрэгцээнд шаардагдах уналга, хөсөг, хүч хэрэгслийн туслалцаа үзүүлэх ажлыг зохион байгуулсан байна.

Чөлөөлөх дайны үед Улсыг аюулаас хамгаалах байгууллагын хариуцсан нэг чухал үүрэг нь япончуудаас хяналтандаа авч тагнуулынхаа бааз болгох зорилгоор Өвөр Монголын Шилийн голын чуулганы Баруун Сөнөд хошууны нутагт байгуулсан Диловын хошуунд харьяалагдаж байсан 1930-аад онд эх орноосоо дүрвэн гарсан монгол иргэдийг буцаан авчрах ажил байв.

Үүний дагуу 1945 оны 8 дугаар сарын сүүл 9 дүгээр сарын эхээр Баруун Сөнөдөд байсан халх 436 өрхийн 1591 хүнийг Дорноговь аймгийн Эрдэнэ сумын нутагт нүүдэллэн ирүүлэх ажлыг зохион байгуулан, хүн, малын тооллого явуулж, 20-оос дээш насны бүх хүмүүсээс байцаалт авч, Дорноговь аймгийн Иххэт, Хар айраг, Ихжаргалан сумдад тараан суурьшуулснаар Диловын хошуунд харьяалагдаж байсан ардууд эх нутагтаа эргэн ирсэн байна. Эргэн ирсэн халх ардуудыг суурьшуулах бодлогыг зохион байгуулалттайгаар явуулж, хуучин Балдан засгийн хошууны харьяат 200 гаруй өрхийг тус аймгийн Дэлгэрхэт, Иххэт, Айраг сумын нутаг Их-эрээн, Хаданхошуу, Баастын тал зэрэг хилээс дотогш 250 гаруй км газруудаар нутаглуулахаар шийдвэрлэж нүүлгэн, Түшээт буюу Ламын гэгээний харьяат болох 200 гаруй өрхийг дотогшлуулан нүүлгэх гэтэл газар нутгийн ба өвс ургацын байдал тохиромжгүй байгаа учир өвөлд нь хязгаарын Улаанбадрах, Хөвсгөл сумын нутагт өвөлжүүлж, хавраас зохистой нутгийг зааж олгох арга хэмжээг авч хэрэгжүүлсэн байна.

1951-1952 онд ДЯЯ-наас ГЯЯ-тай хамтран орон нутагт явуулсан судалгаагаар үзэхэд Дорноговь аймгаас дүрвэгсэд бараг буцаж ирсний дээр Өмнөговь аймгаас дүрвэсэн 2790 хүн амтай 730-аад өрхөөс 1400 хүн амтай 370-аад өрх буцаж ирсэн мэдээ гарчээ. Энэ судалгаагаар 1930 оны эхээр гадаадад гарсан дүрвэгсдээс 2712 хүн амтай 882 өрх айл, 89 мянган мал буцаж ирээгүй гэсэн мэдээ гаргажээ.

Эдний дунд эх орноосоо урвагчид, Японы тагнуулын байгууллагатай хамтран ажилласан иргэд байсан тул тэднийг байцаах, нэр дээр нь байгаа хэрэг материалаар лавлагаа гаргаж шилжүүлэх, баригдаагүй хоцорсон этгээдийг эрэн сурвалжлах

зорилгоор холбогдох мэдүүлэг гаргуулж байв. Мөн олзлогдсон гадаадын цэргийн албан хаагчид ба ажил, сургуульд орох хүсэлтэй гэсэн хүмүүсийг судалж, орон нутгийн гүйцэтгэх захиргаанд шилжүүлж байжээ.

Чөлөөлөх дайны өмнө Улсыг аюулаас хамгаалах байгууллагаас Хятад, Өвөр Монгол, Манжуурын нутагт буй японы цэргийн хүч, байрлал, цэргийн бэхлэлт, зам харилцааны байдлын тухай нэгдсэн мэдээлэл үйлдэж, ДЯЯ-ны удирдлагаар уламжлан нам, засгийн удирдлага болон МАХЦ-ийн командлалд зохих журмаар шилжүүлсэн нь дайныг ялалтаар төгсгөхөд чухал үүрэгтэй байжээ.

Тагнуулын байгууллага чөлөөлөх дайн эхэлсэн үеэс эхлэн 11 дүгээр сарыг хүртэл Өвөр Монголын нутагт идэвхтэй үйл ажиллагаа явуулж, монгол үндэстнийг нэгдэн нийлэх асуудлыг судлах, нам, төрийн бодлого, үйл ажиллагааг ухуулан таниулах сурталчилгаа хийх, тухайн нутгийн ард олны улс төрийн санал сэтгэгдлийг судлах, орон нутгийн засаг захиргааны зохион байгуулалт, бүтцийг боловсруулах, түүнд ажиллах хүмүүсийг шилж сонгох, чөлөөлөгдсөн нутагт үлдэж хоцорсон японы тагнуул, туршуулыг илрүүлэх, тагнуулын сүлжээ зохион байгуулах, дүрвэж гарсан иргэдээ буцаан авчрах зэрэг ажлуудыг гүйцэтгэжээ.

Квантуны армиас зүүн хойт Азийг чөлөөлөх дайнд БНМАУ оролцсон нь Зөвлөлтийн удирдагчидтай харилцан тохиролцож, дайны дараа өмнөд хөрш Хятад болон олон улсад тусгаар тогтнолоо хүлээн зөвшөөрүүлэх алхам хийх холыг харсан шатрын нүүдэл байсан бөгөөд энэ дайнд энхийг эрхэмлэгч улсуудын талд орсноор хожим Нэгдсэн Үндэстний Байгууллагын бүрэн эрхт гишүүн болоход томоохон түлхэц болжээ. Үүнд Монголын тагнуулын байгууллага өөрийн хувь нэмрийг тодорхой хэмжээнд оруулж, чөлөөлөх дайныг ялалтанд хүргэх мэдээ, мэдээллээр нам, төрийн эрх барих байгууллага, Монгол-Зөвлөлтийн цэргийн командлалыг ханган ажиллажээ.

1945 ОНЫ ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНЫ ҮЕИЙН СУРТАЛ- УХУУЛГЫН АЖИЛ БА ӨВӨР МОНГОЛЫН АРД ИРГЭДИЙН ОРОЛЦОО

Докторант На.Батболд

1945 оны Чөлөөлөх дайны 75-н жилийн ой энэ өдрүүдэд тохиож байна. Энэхүү чөлөөлөх дайны цэрэг, тагнуулын үйл ажиллагааны талаар эрдэмтэн судлаачид чамгүй судалгаа хийж, нилээд үр дүнд хүрсэн билээ. Эдүгээ ч уг судалгаа тасралтгүй явагдсаар байна. Судлаач миний хувьд чөлөөлөх дайны үеийн цэрэг-тагнуулын үйл ажиллагаатай зэрэгцэн явуулж байсан суртал ухуулгын ажиллагаа хийгээд Өвөр Монголын ард иргэдийн оролцооны талаар судлан үзэж Та бүхэнд товчхон хүргэж байна.

Зөвлөлт Холбоот Улсаас (ЗХУ) 1945 оны наймдугаар сарын 9-нд Япон Улсын эсрэг дайн зарласан тухай мэдэгдэхэд БНМАУ-ын Засгийн газраас ЗХУ-ын мэдэгдлийг дэмжиж байгаагаа илэрхийлж, “Зөвлөлт-Монголын харилцан туслалцах гэрээ”-гээр хүлээсэн үүргээ гүйцэтгэх, эх орныхоо аюулгүй байдлыг хангах зорилгын үүднээс наймдугаар сарын 10-нд Японд дайн зарлаж буйгаа мэдэгдсэн байдаг. Чөлөөлөх дайнтай холбогдуулж маршал Х.Чойбалсан 1945 оны наймдугаар сарын 10-нд Монголын ард түмэнд хандаж хэлсэн үгэндээ: “Бид... Японы түрэмгийлэн эзлэгч нарыг бут цохисны эцэст бүх монголчуудыг эрх чөлөөтэй, тусгаар тогтносон, бүрэн эрхт нэгэн ах дүү улс гэр болгон нэгдүүлэх явдлыг хангах болно” гэж тэмдэглэсэн байдаг.

Монгол, Зөвлөлтийн цэрэг 1945 оны наймдугаар сарын 10-наас эхэлж Өвөр Монголын зүүн, баруун хэсгийн хэд хэдэн чиглэлээр цөмрөн орж, чөлөөлөх дайныг явуулсан. Ийнхүү явуулахдаа БНМАУ-ын Засгийн газраас: “Алдар гавьяат улаан цэрэг нь Ази тивийн ард түмний амгалан тайван байдлыг тогтоон агуу их Монголын ард түмнийг нэгдүүлж, тэдэнд үндэсний эрх чөлөө олгох, тусгаар тогтносон гэр улс болгохын тулд Японы булаан эзлэгчдийн өмнөөс шудрага дайны илд мэсийг өргөв ... Монголчуудаа Та нар боолчлон дарлагч этгээдүүдтэй эсэргүүцэн тэмцэгтүн. Япончуудтай ар талаас нь тэмцэх байлдаанд явагтун” хэмээн уриалга гаргажээ. Чөлөөлөх дайны явцад чөлөөлөгдсөн нутгийг тохинуулах, ард иргэдийг БНМАУ-ын харьяанд нэгдэн орохыг ухуулах, сурталчлах ажлуудыг явуулах үүднээс МАХН-ын Төв Хорооноос

1945 оны наймдугаар сарын 23-ны өдрийн 60 дугаар хурлын тогтоолоор Намын Төв Хорооны Суртал ухуулгын хэлтсийн дарга Нямтайширын Лхамсүрэнгээр толгойлуулсан Засгийн газрын комиссыг чөлөөлөгдсөн нутагт ажиллуулахаар томилжээ. Уг комиссоос чөлөөлөгдсөн нутгуудад ажиллаж, хошууг шинээр зохион байгуулах, хошуудын даргыг томилох, Японтой харилцаатай иргэдийг нутгийн ардын тусламжтайгаар илрүүлж баривчлах зэрэг ажлуудыг явуулж хэд хэдэн тушаал шийдвэрүүдийг гаргасан байдаг.

БНМАУ-ын Засгийн газраас явуулж буй бодлого, үйл ажиллагааг ухуулан сурталчлах, Японы цэрэг-тагнуулын байгууллагыг илрүүлэх, үлдэгдлийг цэвэрлэх ажлыг явуулахаар Дотоод явдлын яаманд тусгайлан хүмүүсийг сонгон авч цэрэг, улс төрийн талаар сурган боловсруулж хэд хэдэн бүлэг болгон бэлтгэжээ. Мөн Дотоод явдлын яамны сайд “Хувьсгалт цэргийн байлдаж буй анги нэгтгэлүүдийн ар талд журам зарчмыг зохион хангах, ар талыг хамгаалах хөдөлгөөнт отрядуудыг байгуулах тухай” 301 дүгээр тушаалыг гаргажээ. Уг тушаалд байлдаанд орсон цэргийн анги, нэгтгэлүүдийн ар талд журам дэглэм сахиулж, ар талыг хамгаалахын хамт Японы тагнуул, хорлон сүйтгэгч, Монголын оргодлуудыг илрүүлэн баривчлах, чөлөөлөгдсөн ард түмэнд БНМАУ-ын төрийн бодлогыг ойлгуулах үүргийг өгсөн байна.

Үүний өмнө Өвөр Монголын нутагт япончуудын дарлалыг эсэргүүцэн Дэлгэрцогт гэгч өөрийн дотно сайн нөхөд Хурцбилэг, Бүрэнсайн, Дугаржав нар лугаа нууцаар ярилцан хэлэлцэж 1943 оны наймдугаар сард “Дотоод Монголын Ардын нам”-ыг үүсгэн байгуулжээ. Уг намын зорилго нь “Дотоод Монголын ард түмнийг эрх чөлөөтэй болгох, Японы дарлагдлаас гаргах, Дотоод Монголд Японы удирдлагаар байгуулсан засгийг халж өөрчлөх” байв. Улмаар намын үйл ажиллагаа өргөжиж тус ондоо анхдугаар хурлыг намын гишүүн бөгөөд Хаалган хотын аж амьдралын хорооны барааны ажилчин Ядамжавын гэрт хийжээ. Анхдугаар хурлаас

Нэгд: Намд нөлөө бүхий хүмүүсийг элсүүлэх,

Хоёрт: Өвөр Монголыг Японы дарлагдлаас чөлөөлөхөд БНМАУ-аас тусламж авах гэсэн үндсэн зорилтыг дэвшүүлжээ. Мөн намын гишүүн Сайжингаа, Гомбожав нарыг Дэ вангийн засгийн ордонд ажиллуулж, Дэ вангаас явуулж буй ажил ба ард түмний зан байдлыг анхаарч байхыг үүрэг болгон ажиллуулж байв. Ийнхүү Өвөр Монголын нутагт Монгол-Зөвлөлтийн армид дэмжлэг үзүүлэх боломжтой нэгэн бүлэг үүссэн байв.

1945 оны наймдугаар сарын 11-ний өдөр Зөвлөлт-Монголын цэрэг Хамба ламын сүмийг эзлэхэд Өвөр Монголын хувьсгалт намын дарга Дэлгэрцогт, гишүүн Бүрэнсайн,

БНМАУ-ын Засгийн газрын төлөөлөгч Н.Лхамсүрэн

Хурцбилэг нар тус цэргийн анги дээр очиж, намын ажил байдлыг танилцуулжээ.

Чөлөөлөгдсөн нутагт Дотоод явдлын яамнаас ажиллуулсан тусгай группүүдийн ерөнхий зохион байгуулалт, үйл ажиллагаа нь тухайн чөлөөлөгдсөн нутгийн хүн ам төвлөрсөн газарт байрлаж, ажилтнууд бүлэг бүлгээр ойр хавийн нутагт суурьшиж буй иргэдэд хүрч ухуулга, таниулгын ажлыг гүйцэтгэж байв. Тухайлбал: Батхаалгын тусгай группийг хурандаа Б.Дордог, хошууч Э.Халтар нар удирдан ажиллажээ. Тус группээс 1945 оны есдүгээр сарын 4-9-ний өдрүүдэд Ширээтийн хошуунд ухуулагч Дорж, Аюурзана нар, Дархан бээлийн хошууны Хавцал, Шар толгой зэрэг газруудаар ухуулагч Шарав, Сэдэв нар ажилласан байна. Тус Батхаалгын группээс дайны хугацаанд: Дархан бээлийн хошууны 66 өрхийн 504 ардад, үүнээс эрэгтэй 233, эмэгтэй 271, Муумянган хошууны 24 өрхийн 251 ардад, үүнээс эрэгтэй 114, эмэгтэй 137, Ширээт шавийн хошууны 207 өрхийн 518 ардад, нийт эрэгтэй 261, эмэгтэй 257. Эдгээр бүгд 397 өрх айлын 1273 хүнд өөрийн суртал ухуулгын ажлыг нэвтрүүлжээ.

Тухайн үед япончуудын зүгээс энгийн ард иргэдийг тонон дээрэмдэх, мал хөрөнгийг булаах, орос бараа, материал хэрэглэвэл Монголын тагнуул хэмээн баривчлан хорих, занчих явдал ихээхэн гаргаж байжээ. Тухайлбал: Ширээт сүмийн нэгэн ардын 20 гаруй мориноос зөвхөн ганц морь үлдээж, үхэр нэгэн адил ганцыг үлдээгээд бусдыг авч, нэг үхрийн үнэд сайн бол 3 ам ембүү, их төлөв үнэгүйгээр авч байжээ. Мөн Ширээт сүмийн өндөр настан Нансалмаа: “Хувьсгалч үзэлтэй хүмүүс буюу орос бараа эдэлж хэрэглэсэн хүмүүсийг баривчлуулж байв. Ямар нэг сэжиглэлтэй хүмүүсийг баривчлан аваад зодож занчих буюу хүйтэн усаар гэдсийг дүүргэх зэргээр эрүү шүүлтийг хэрэглэж байцаадаг байсан болой. Тэр ч байтугай арваад настай охиныг

хүртэл чихэр боовоор хуурч тагнуул хийлгэдэг байсан. Япон шиг жигшүүртэй улс дэлхий дээр нэг ч үгүй” хэмээн уйлан ухуулагч нарт ярьж байжээ.

Ухуулах ажлын хүрээнд Өвөр Монгол ард иргэдийн зүгээс доорх асуултуудыг ихэвчлэн тавьж байжээ. Үүнд:

1. БНМАУ-ын шашин шүтлэгийн асуудал,

2. БНМАУ-ын нийгмийн харилцааны талаар,

3. БНМАУ-тай Өвөр Монгол нэгдэх эсэх, нэгдэх талаар санал хураалт явуулах,

4. БНМАУ-аас дүрвэж ирсэн иргэд буцаж нутагтаа очиж болох эсэхийг асууж байжээ.

Үүнээс гадна чөлөөлөгдсөн нутгийн ард иргэд нийтээр нэгдэн БНМАУ-д нэгдэх тухай бичгийг үйлдэн өргөн барьж байв. Тухайлбал: Хөлөнбуйрын Шинэ барга, Зүүн гарын Хөл шар хошууны ард иргэдээс 1945 оны есдүгээр сарын 25-ны өдөр хуралдан: “БНМАУ-ын Засгийн газарт: Хөлөн буйрын шинэ барга, зүүн гарын хөл шар хошууны шар хар ард олны санал” гэсэн бичгийг үйлдэн өргөн барьжээ. Уг бичигтээ: “Эдүгээ бид нар Их Монголоос тасарч удаанаар бусад угсаатанд захирагдаж агсаны дээр нэн ялангуяа 14 оны дотор аюулт харгис Японы эзэрхэг шунахай цэрэг, иргэдийн дарлагдалд мөлжигдөж, туйлын гашуун зовлонг эдэлж байтал энэ оны наймдугаар сарын 9 ба 10-ны өдрүүдэд СССР ба БНМАУ-ын баатар зоригт цэргүүд аянга, цахилгаан мэт орж ирмэгц харгис япон нар түүний сүр хүчинд хоромхон зуур ор мөргүй сөнөсөн. Харьяат хошууны ард олон харанхуйгаас гэгээн гэрлийг үзсэн мэт түмэнтээ баярлаж үндэс угсааны журмаар Их Монгол Улс лугаа нэгдэж Богд дээдэс Чингис Хааны гэрэлт алдрыг дахин мандуулах болтугай хэмээн ард түмэн бид бүгдээр өргөн санаа гаргаж хүсэх нь. Эрх биш санал ёсоор шийтгэхийг гуймой. Үүний тул өргөв” хэмээн нийт 172 хүн гарын үсэг зурсан бичиг үйлджээ.

Энэ мэтчилэн Өвөр Монголын ард иргэдээс чөлөөлөх дайны үйл ажиллагааг хөхүүлэн дэмжиж, нэгэн улс гэр болохыг туйлаас хүсэн ухуулагч бүрт хүсэлт тавьж байв. Мөн Өвөр Монголын ард иргэдээс чөлөөлөх дайны үйл ажиллагаанд оролцож буй анги нэгтгэл, тусгай группүүдэд ажиллаж ихээхэн хувь нэмрийг оруулж байжээ.

Өвөр Монголын цэрэг Жаргал, Дамиран хоёр нь Монголоос гарснаас хойш байлдагч нарын нэг адил харуул манааны үүргийг сайнаар гүйцэтгэж, хятад хэл сайн мэдэх учир аливаа хятадуудтай хэл нэвтрэлцэх явдалд хэлмэрчлэн үлэмж их тус болсон, Жаргал нь анх Дөрвөд тийш явж байх үед ангийн тэргүүнд сэргийлэх манаанд яваад Хятадын 100 гаруй дээрэмчдийг үзмэгц тэрхүү цагийн дотор эргэж ангидаа мэдэгдэн дээрэмчидтэй гэнэт тулгарах аюулаас сэргийлсэн, Улаанцавын

чуулганы Ширээтийн хошууны зүүн сумын иргэн Дашжавын Эрдэнэбаатар БНМАУ-д нэгдэхийг ухуулах явдалд нийтийг удирдсан ба Хятадын улаан цэрэгт адуу 100, урт буу 43, сум 1200, гранат 70 ширхэгийг өгч ихээхэн туслалцаа үзүүлж байжээ.

Манжуур, Хайлаарын чиглэлийг “Дөл” хэмээн нэрлэж, группийг ДЯЯ-ны ажилтан Ц.Даваажав, сургагч Г.А.Савельев нараар удирдуулан ажиллуулжээ.

“Дөл” группийн илтгэлээс үзэхэд: “1945 оны наймдугаар сарын 11-ний өдөр Улаанбаатараас гарч Чойбалсан хотноо 12-ны өдрийн оройн найман цагт ирсэн ... Чойбалсан хотноо 5 хоногийн турш отрядын байлдагч 100 хүнийг аймгийн намын хороо, аймгийн яам, хэлтсийн дарга нартай харилцан ярилцаж авсан” хэмээн дурдсан байдаг. Тус групп наймдугаар сарын 19-ний өдөр наймдугаар застав Баян-Уулын хойд талаар хил нэвтэрч, Шинэ баргын төв хошуу байрлаж байсан Алтан-Эмээлийг чөлөөлж, Японы бага сургуулийн байранд байрлажээ.

Алтан-Эмээлээс “Дөл” групп тагнуулын холбогдолтой чухал баримт материалыг олзолж авсан ба байрлалаа орхин зугтсан Японы тагнуулчдыг илрүүлж, Б.Даваажав, сумангийн дарга Бат-Очир нарын морин групп Далай нуурын чиглэлд мөрдөн хөөж, японы тагнуулчдыг Хэрлэн голын эрэг дээр гүйцэж устгажээ. Энэхүү тулааны талаар: “Монгол Улсын хил хамгаалалтын түүхэн тэмдэглэл”-д: “Япончууд голын эрэг, усан дотроос шууд гал нээсэн байна. Хилчид тэднийг бүслэн заримыг устгаж, үлдэгсдийг амьдаар барихыг оролдсон ч дайсны зарим нь амиа хорлож, цөөн хүн аргагүйн эрхэнд олзлогджээ. Манай талаас жолооч Дамчаа хөнгөн шархадснаас өөр хохиролгүй, харин ахмад Б.Даваажав, Лувсандагва, дэслэгч Жанцан, бага дэслэгч Гомбожав, байлдагч Гончигням, Данзандаржаа, Гэрэл нар онцгой авхаалж гарган байлдав” хэмээжээ. Энэхүү тулгаралтын тухай: “Дөл” сонины эрхлэгч Ш.Бат-Очир “Дөл сонины хэвлэгч Ц.Данзандаржаагийн тагнуулын мэдээг хүлээн авмагц ... манай отряд шууд дайран довтлохоор сөрөг давшиж билээ. Өглөөний 9 цагаас оройн 4 цагийн хооронд Японы бүлэг хүчийг бут цохиж, үлдэгсдийг буулган авч Зөвлөлтийн цэргийн командад тушаасан билээ. Оршуун голын тулалдаанд “Дөл” сонин бүх бүрэлдэхүүнээрээ оролцож байлдсан бөгөөд үсэг өрөгч Содном, Ханзан, хэвлэгч Данзандаржаа нар онц гарамгай тулалдсан учраас орой нь Засгийн газрын чөлөөлөгдсөн нутагт ажиллах комиссын дарга Нямтайширийн Лхамсүрэн тэд нарыг отрядын жагсаалын өмнө гаргаж сайшаан баяр хүргэж байсан билээ” гэж тэмдэглэсэн байдаг.

“Дөл” группийн үйл ажиллагааны үндсэн чиглэлийн нэг нь чөлөөлөгдсөн нутгийн ард

ОРОН БҮХНИЙ ПРОЛЕТАРИ НАР НЭГДЭГТҮН

Дөл

1945
15
№ 39

Чойбалсан аймгийн
Намын хороо ба
Засгийгаа сонин.

Манжуур, Хайлаарын чиглэлд ухуулах сурталчлах ажлын хүрээнд гарч байсан “Дөл” сонин

иргэдийг тохинуулах, БНМАУ-тай нэгдэх тухай ухуулах, сурталчлах ажлыг гүйцэтгэх байсан. Тус ажлын хүрээнд Дорнод аймгийн “Дөл” сонины ажилтан, албан хаагчдыг группийн бүрэлдэхүүнд оруулжээ. Чөлөөлөгдсөн нутагт “Дөл” сонины албан хаагчид ухуулах, сурталчилгааны ажлыг эрхлэн явуулж байсан боловч “Дөл” сонины дугаарыг гаргаагүй байна. Тухайлбал: Монголын Үндэсний Төв Архивын Нам, Олон нийтийн байгууллагын баримтын төвд хадгалагдаж буй Дорнод аймгийн “Дөл” сонины 1945 онд хэвлэгдсэн дугаарт Чөлөөлөх дайн зарласны дараа 1945 оны наймдугаар сарын 15-ны өдөр №39 дэх дугаар “Монголын ард түмний ариун дайн” нэртэйгээр хэвлэгдэн гарсан байна. Улмаар №40 дэх дугаар чөлөөлөх дайн дууссаны дараа буюу мөн оны 9 дүгээр сарын 6-ны өдөр хэвлэгдэн гарчээ. Үүнээс үзэхэд чөлөөлөгдсөн нутагт тусгай дугаар гаргасан байж болзошгүй юм.

Чөлөөлөх дайнд оролцсон

Манжуур, Хайлаарын чиглэлийн “Дөл” групп: “Хөлөн буйрын бүх монголчуудыг Монгол Улс лугаа нэгтгэхийг биелүүлэхийн тулд ... ард олны дотор Монгол Ард Улс лугаа нэгтгэх тухай зарлал, ятгалгыг явуулах бөгөөд үүндээ Халх монгол ба Хөлөн буйрын монголчууд нь хэл бичиг, хэв заншил, аж амьдрал, нутаг бэлчээр эдгээр үндсээр нэг адил ... Баргын ба Халх монголын ард түмний ойрын ба ирээдүйн зорилго нэг тул бидний Баргын монголчууд нь Халх монгол ард улсаа түшиж, тэдний элбэрэл тусламжинд найдаж амьдрах хэмээн үнэн үгийг ард олны тархи, мэдрэлд шингэтэл ухуулан ойлгуулах явдлыг зорилго болгон ажилласан” байна.

ДЯЯ-ны Манжуур, Хайлаарын чиглэлийн “Дөл” группийн ухуулах-сурталчлах ажлын үр дүнг 1945-1946 онд БНМАУ-ын харьяат болохоор Дорнод аймагт нүүдэллэн ирсэн Баргын ард иргэдээс харж болохоор байна. Тухайлбал: 1945 оны арваннэгдүгээр сарын 5-ны өдөр БНМАУ-д нүүж ирсэн 256 өрх айл, 471 эрэгтэй, 542 эмэгтэй, 109 лам нар зэрэг олон баримтуудыг дурдаж болохоор байна.

ДЯЯ-наас явуулсан “Дөл” групп нь чөлөөлөх дайнд Манжуур, Хайлаарын чиглэлийн олон монголчуудыг Японы дарлалаас чөлөөлж, энгийн ард иргэдийн эд хогшилыг тонон дээрэмдэж, амь насыг нь бүрэлгэж байсан японы үлдэгдэл цэрэг, Японы цэргийн хүчтэй хамтран ажиллаж байсан иргэдийг илрүүлэн Япон Улсын бодлого, үйл ажиллагаатай холбоотой олон чухал баримтуудыг олзолж авсан нь ач холбогдолтой ажил болжээ.

Чөлөөлөх дайны төгсгөлийн талаар судлаачид нилээд судалгааны өгүүллүүд гаргасан тул энд нуршихаас татгалзав. Дээр дурдсан баримтуудаас үзвэл, Өвөр Монголын ард иргэд БНМАУ-ын цэргийн хүч болоод тусгай группүүдэд бүхий л талын дэмжлэг үзүүлж, дайны үйл ажиллагаанд үнэтэй хувь нэмэр оруулжээ. Тэд Япон Улс бууж өгөхөд зарим хэсэг нь БНМАУ-ын харьяат болохоор ирж, Өвөр Монголын нутагт үлдсэн олон арван хүмүүсийн гавьяатай үйл хэргийг чөлөөлөх дайнд оролцсон анги нэгтгэлийн удирдлагуудаас БНМАУ-ын одон медаль, үнэ бүхий зүйлээр шагнуулахаар тодорхойлон Засгийн газарт явуулж байжээ.

АРХИВЫН САН ХӨМРӨГӨӨС

БНМАУ-ЫН ЗАСГИЙН ГАЗРААС ӨВӨР МОНГОЛЫН АРД ТҮМЭНД ТАРААЖ БАЙСАН УХУУЛАХ ХУУДАС

Хөрвүүлсэн: С.Цэрэндэжид

ТЕГ-ын Тусгай архив. Х-2, д-1, хн-236

Монгол ах, дүү нараа !

Эрх чөлөөт Бүгд Найрамдах Монгол Улсын Засгийн ордноос Японы булаан эзлэгчдийн дарлагдлын дор гашуун зовлонг амсаж буй монгол ах дүү та нарт анхааруулах нь:

Японы бусад улсын газар орныг булаан эзлэгчид болвоос Монголын ард түмний эрх ашгийг урван худалдагч Дэмчигдонров ван ба түүний гар хөл болох этгээдүүдийг түшиглэж, монгол угсаатныг салган сарниулагч, тэдний үндэсний алдар нэр болон улс гэрийн тусгаар



ТЕГ-ын Тусгай архив. Х-2, д-1, хн-236

тогтнолыг устгагч, шарын шашин, мөргөлчдийн эрдэм боловсролыг доромжилж, Монголын эд баялаг хөрөнгийг тонон дээрэмдсээр байна.

Ах, дүү нараа:

Олон зуун жилийн турш зүдэрч зовсон буюу Монгол Улс Японы дарлал боолчлолоос салж, эрх чөлөөтэй болох хэмээн эрт урдаас хүлээн ядаж байсан өдөр одоо ирэв.

Манай жинхэнэ хань бөгөөд эрх чөлөөг олгогч Зөвлөлт Холбоот Орос Улс нь бидэнд тусламж өгч Японы эзэмдэгчдийн өмнө хамтарсан шударга тэмцлийг явуулахыг уриалж байна.

Монголчуудаа бүрэн эрхт Монгол Улсын Засгийн ордон нь та нарыг зэвсгээ гартаа барь хэмээн манай улсын эрх чөлөөт ард түмний өмнөөс уриалж байна.

Гагцхүү ЗХУ-тай учран найрамдсанаас бид нарт эрх чөлөө, баяр цэнгэл ирж, манай аж амьдрал мандаж байгаа нь түүхэнд ил тодорхой байна.

Хүчит улаан цэрэг нь манай улсыг боолчлогдох аюулаас олон удаа авран өршөөсөн билээ. Улаан цэрэг болвоос Европын 1921 он бөгөөд Чингисийн 716 онд Японоос явуулсан Барон Унгерн ба Цагаан Оросын оргодол дээрэмчдийн харгис ноёрхлоос биднийг аварсан

билээ.

Улаан цэрэг бол Чингисийн 734 онд манай нутагт Халхын гол буюу Номонханы орчим газраар цөмрөн довтолсон Японы харгис махчин нарын гар саврыг тас цохисон билээ. Тэр цагт манай гайхамшигт цэрэг болвоос хүчит улаан цэргийн халуун тусламжтайгаар Японы булаан эзлэгчдийг бүрмөсөн бут цохиж, манай улсыг боолчлогдох явдлаас аварсан билээ.

Аугаа их Зөвлөлт Холбоот Орос Улсын ард түмэнтэй манай хэлхээ холбоо нь цусаар гагнагдсан юм. Зөвлөлт Холбоот Орос Улсын ард түмэн болвоос манай улсын баялгийг өсгөн нэмэгдүүлж, манай үндэсний соёл, эрдэм, төрийг нэмэгдүүлэх явдалд тусласан ба одоо ч тусалсаар байна.

Ардууд аа:

Эдүгээ алдар гавьяат улаан цэрэг нь Ази тивийн амгалан тайван байдлыг тогтоох, аугаа их Монголын ард түмнийг нэгдүүлж, тэдэнд үндэсний эрх чөлөө олгох, тусгаар тогтносон улс гэр болгохын төлөө Японы булаан эзлэгчдийн өмнөөс шударга дайны илд мэсийг өргөв.

Монголчуудаа:

Улаан цэрэг бол Америк, Ингрис (Англи) улсын цэрэгтэй хамтаар байлдаж, Дойч (Герман) улсын фашистын цэргийг бут цохин Европын ард түмэнд амгалан тайван, эрх чөлөөг олгон өгч тэд нарыг хүнд дарлагдлаас чөлөөлөв.

Европын бүх ард түмэн нь улаан цэргийг эрх чөлөө олгогч цэрэг хэмээн магтан сайшааж байна. Мөн Японы булаан эзлэгчид ба тонон дээрэмдэхээс та нар нэгэн адил чөлөөлөгдөх цаг одоо иржээ.

Монголчуудаа та нарыг боолчлон дарлагч этгээдийг эсэргүүцэн тэмцэхтүн.

Японы цэргийн ар талаас тэмцэх байлдаанд явахтун.

Японы тагнуулч Дэмчигдонров ван ба түүний гар хөл болсон этгээдүүдийг хөөн зайлуулахтун.

Монголын ард түмэнд эрх чөлөөг олгосон улаан цэрэгт тусламж хүргэхтүн.

Японы цэргийн албанд буй Монголын цэрэг, дарга нараа: Буу зэвсгээ Монголын ард түмний дайсан болсон Японы булаан эзлэгчдийн эсрэг эргүүлэн хандуулахтун.

Японы дарга, сургагч нарыг сөнөөхтүн.

Улаан цэрэг ба Монгол ардын хувьсгалт цэргүүдийн талд орж ирэхтүн.

Та нар болвоос манай ард түмний тусгаар тогтнол, алдар нэрийн төлөө тэмцэлд зүтгэсэн ах, дүү нарын нэгэн адил тооцогдох болно.

Монголчуудаа:

Японы булаан эзлэгчдийн эсрэг эрх чөлөөний шударга дайнд урагш давшин байлдахтун.

Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Засгийн ордноос

ХЯЗГААРЫН 7 ДУГААР ОТРЯДЫН УЧАСТОК ДЭЭР ТУСГАЙ СУМАН БАЙГУУЛАХ ТУХАЙ

Хөрвүүлсэн: Д.Наранцэцэг



ТЕГ-ын Тусгай архив

ДОТООД ЯВДЛЫН ЯАМНААС ГАРГАСАН ТУШААЛ

1945.6.26 №277

Утга нь: Хязгаарын 7 дугаар отрядын участок дээр тусгай суман байгуулах тухай

Нэгдүгээр зүйл. Гүйцэтгэх буюу байлдааны тусгай үүргийг гүйцэтгүүлэхийн тулд хязгаарын 7 дугаар отрядын участок дээр 4 салаа буюу 157 хүнээр бүрэлдэхүүн болсон хөдөлгөөн бүхий отряд суман нэгийг байгуулсугай.

Хоёрдугаар зүйл. Шинээр байгуулагдах дээрх суманг 7 дугаар отрядын дүгээр сумангийн штаб ба нэгээс бусад заставуудын офицер, сержант болон цэргүүдээр байгуулсугай.

Гуравдугаар зүйл. Дээрх суманг замын Бингхүү булгийн дэргэд суурьшуулсугай.

Дөрөвдүгээр зүйл. Эл суманг



ТЕГ-ын Тусгай архив

байгуулах ажиллагааг 1945 оны 8 дугаар сарын 1-нээс наана дуусгасугай.

Тавдугаар зүйл. Эл тушаалд хавсаргасан хуваарийн ёсоор ДЯЯ-ны тусгай бэлтгэл пунктээс зохих төрлийн зэвсгийг тавин олгож, дээрх суманг зэвсэглэсүгэй.

Зургадугаар зүйл. Дээрх сумангийн байлдааны ба улс төрийн бэлтгэл болон техник материалын хангалт зэргийг хариуцан удирдах явдлыг Хязгаарын цэргийн хэргийг эрхэлсэн орлогч сайд хошууч генерал Доржид даалгасугай.

Долдугаар зүйл. Гүйцэтгэх буюу байлдааны ажиллагааны асуудлын талаар дээрх суман нь тагнуулын ажлыг эрхэлсэн миний орлогч Улсыг аюулаас сахиж хамгаалах хурандаа Дордогт захирагдах болно.

Наймдугаар зүйл. Хязгаарын 7 дугаар отрядын 2, 3, 4, 5 дугаар заставуудын харьяалсан участокийн хилийн хамгаалалтыг зохиохдоо гүйцэтгэх тагнуулын ажлыг хүчтэйгээр явуулах ба орон нутгийн туслах группүүдийг ихээхэн хэмжээгээр ашиглах зэргээр зохиож хилээ хамгаалах явдлыг Хязгаарын цэргийн даргад даалгасугай.

ДОТООД ЯВДЛЫН ЯАМНЫ САЙД, УЛСЫГ АЮУЛААС САХИЖ ХАМГААЛАХ, ХОШУУЧ ГЕНЕРАЛ ШАГДАРЖАВ

Чөлөөлөх дайны цеэр тараагдаж байсан ухуулах хуудас

1945 ОНЫ 8 ДУГААР САРЫН 10-НЫ ӨДӨР РАДИОГООР БҮГД НАЙРАМДАХ МОНГОЛ АРД УЛСЫН ЕРӨНХИЙ САЙД, УЛСЫН ШАЛГАРСАН БААТАР, МАРШАЛ НӨХӨР ЧОЙБАЛСАНГААС МОНГОЛЫН АРД ТҮМЭНД АНХААРУУЛАН ХЭЛСЭН ҮГ

Хөрвүүлсэн: На.Батболд



ТЕГ-ын Тусгай архив

Нөхдөө. Эрэгтэй, эмэгтэй ардууд аа, эрэгтэй, эмэгтэй ажилчдаа, оюуны хөдөлмөрийн ажилчдаа.

Монгол ард улсын Хувьсгалт цэргийн байлдагч, түрүүч, офицер, генералууд аа

Монгол ард улсын харьяат нараа

Японы түрэмгийлэн эзлэгчдийн дарлагдлын доор зовж буй ах дүү монголчуудаа. Барга, цахар харчин, өвөр монгол ба бусад бүх монголчууд аа.

Өнөөдөр наймдугаар сарын 10-нд манай Засгийн газраас манай улс Японтой байлдах шийдвэрийг гаргав.

Засгийн газрын тушаалын ёсоор манай цэргүүд улсын хилийг давж, Өвөр Монголын нутаг дэвсгэр дээр ороод амжилттай урагш давшиж, манай мах цусны ах дүү болох Өвөр Монгол овогтныг



ЗХУ-БНМАУ-ын арми Өвөр Монголын нутагт

Японы боолчлолоос чөлөөлж байна.

Манай Засгийн газраас авч явуулсан энэ алхам бол гэнэтийн тохиолдсон зүйл биш юм. Юу гэвэл олон зуун жилийн турш бүх Монгол овогтон өөрийн эрх чөлөөгөө тусгаар тогтнуулахын тулд тэмцсээр ирсэн явдал Та бүхэнд тодорхой юм аа.

Харин гагцхүү манай улсын ард түмэн бол эрх чөлөө, тусгаар тогтнох явдлыг 1921 оны ардын хувьсгалаар байлдан авах жаргал тохиолдсон юм аа.

Эрх чөлөөтэй тусгаар тогтнохын тул тэмцэхэд манай ард түмний зам дээр Японы фашистууд үргэлжид зогсож байсан ба одоо ч зогсож байгаа бөгөөд тэд манай эрх чөлөөтэй улсыг эзлэн боолчлохыг олон удаа оролдсон байх юм. Мөн тэд бол Монголыг урван худалдагч Дэ вангийн тусламжтайгаар манай төрөлхийн ах дүү болох Өвөр Монгол, Барга зэргийн монгол овогтныг дарлан зовоож байна.

Манай эрх чөлөөт улсын дотор ба түүнчлэн манай улсын гадна оршин сууж байгаа монгол хүн нэг бүрээс өнгөрсөн түүхт ба одоо ч атугай Японы түрэмгийлэн эзлэгч нар болбол Монголчуудын эрх чөлөө ба тусгаар тогтнолын хамгийн заналтай дайсан хэзээд мөн байсан гэгчийг мэднэ. Өөрийн эрх чөлөө ба тусгаар тогтнох явдлыг манай ард түмэн, зөвлөлтийн баатар ард түмэн болоод түүний улаан цэргийн ах дүүгийн тусламжтайгаар байлдан олж авсан бөгөөд биднээс гадаадын түрэмгийлэн эзлэгчид

ЗХУ-БНМАУ-ын арми Өвөр Монголын нутагт

болон манай ард түмнийг эзлэн боолчлогч нартай тэмцэж байсан хамгийн хүнд бэрх цаг үеэр бидэнд ах, дүүгийн тусламжаа хүргэсэн юм.

Зөвлөлтийн ард түмэн ба түүний баатар улаан арми бол бидэнд гагцхүү өөрийн эрх чөлөө, тусгаар тогтнох явдлыг байлдан олж авахад туслахаар барахгүй, мөн тэрхүү тусгаар тогтнох явдал ба эрх чөлөөг бэхжүүлэн хамгаалах бололцоог өгч өөрийн шилдэг хөвгүүдийн цусыг байлдааны талбар дээр урсгаж цаг үргэлж сэтгэл харамгүйгээр тусламжийг үзүүлж, манай ард түмнээс амгалангаар хөдөлмөрлөх, манай эрх чөлөөт улсыг цэцэглэх явдлыг хангаж байна.

Дайны аюулаас түргэнээр устгах ба нийтийн амгалан тайвныг тогтоохыг зорьж байна. Зөвлөлтийн ард түмэн бол дайны галыг шатаагч фашистын сүүлч нь болох Японы самурай нарт шударга хариуг өгөхөөр илд мэсээ холбоотны хамтаар өргөн далайж байна.

Бид баатар улаан цэрэг болон нэгдсэн улс үндэстний хамт Японы фашистуудыг бүрмөсөн устгаж, Японы түрэмгийлэн эзлэгч нарыг бут цохисны эцэст бүх Монголчуудыг эрх чөлөөтэй, тусгаар тогтносон бүрэн эрхт нэгэн ах дүү улс гэр болгон нэгдүүлэх явдлыг хангах болно.

Иймийн учраас манай бүх ард түмэн бол Японтой байлдах ба Японы фашистыг устгахаар

Маршал Х.Чойбалсан Өвөр Монголын нутагт

тэмцэж буй ардчилсан улсуудын нэгдмэл эгнээнд хамтрах тухай зарласан өөрийн засгийн газрын шийдвэрийг нэгэн дуугаар хүлээн авах буй хэмээн итгэж байна.

Тусгаар тогтносон улс болгон нэгдүүлэх манай ариун ба шударга дайны хариуцлагатай цаг үед би Ардын хувьсгалт Засгийн газар ба манай ардын хувьсгалт намын өмнөөс хүн бүр өөрийн хариуцсан ажил дээрээ тайван бөгөөд итгэл найдвартайгаар хөдөлмөрлөх, манай зохион байгуулалт ба сахилга батыг ажил бүхэн дээр бататгах, шударга ба шургуугаар хөдөлмөрлөж, манай улсын хөгжилт, амжилтыг гаргах, манай хайрт ардын хувьсгалт цэрэгт амь, биеийг хайрлахгүйгээр туслахыг уриалан дуудна.

Бүх монголчуудын төлөөнөө болон манай зүг хэргээ өөрийн эрх чөлөөт тусгаар тогтносон эх орны төлөөнөө эрэлхэг хатуугаар байлдахыг миний бие манай ардын хувьсгалт цэргийн байлдагч, түрүүч, офицер, генералуудаас уриалан дуудна.

Бүх хүчээ манай ардын хувьсгалт улаан цэрэгт зориулан туслахтун. Бүх хүчээ бүх монголчуудын заналт дайсан Японы самурай нарыг түргэн бут цохиход зориулахтун.

Манай эх орны алдар нэр, эрх чөлөө ба тусгаар тогтнол мандтугай.

Нийтийн дайсны эсрэг байлдаж буй манай ардын хувьсгалт цэрэг ба бидэнтэй мөр зэрэгцэн байлдаж буй Зөвлөлт Холбоот Улсын баатар улаан цэрэг мандтугай.

Агуу их Сталин мандтугай.

Чөлөөлөх дайны цеэр тараагдаж байсан ухуулах хуудас

Чөлөөлөх дайны цеэр тараагдаж байсан ухуулах хуудас

ДУРСАМЖ, ДУРДАТГАЛ

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН ДОТООД ЯВДЛЫН ЯАМНЫ МАНЖУУР ХАЙЛААРЫН ЧИГЛЭЛИЙН ТУСГАЙ ГРУППИЙН ГИШҮҮН Г.НАМХАЙДАГВЫН ДУРДАТГАЛ

Хөрвүүлсэн: Д.Отгонцэцэг

Гончигдоржийн Намхайдагва 1918 онд Өвөрхангай аймгийн Нарийнтээл суманд төрсөн.

1938-1940 онд ДЯЯ-ны Хязгаарын ба Дотоодын цэргийн Төв сургууль, 1940-1941 онд ДЯЯ-ны Хэвлэх үйлдвэрт ажилтан, 1942-1943 онд ДЯЯ-ны Төв сургуулийн 1 жилийн курс, 1943-1947 онд Хязгаарын 31 дүгээр отрядын 5 дугаар тасагт туслах ажилтнаар ажиллаж байжээ.

1945 оны 8 дугаар сарын 7-8-ны өдөр Ц.Даваажав даргын өгсөн үүрэг ёсоор бага даргатай арваад орос цэргийг удирдан нуувч ухуулж байтал 8-ны өдрийн 17 цагийн үед гэнэт түгшүүрийн дохио энд тэндгүй цуурайтлаа. Үй түмэн танк, машин техникийн цуваа хөвөрч эхэллээ.

Сэтгэл хөдөлсөн офицерууд явахсан хэмээж байтал 1945 оны 08 дугаар сарын 12-нд Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга Н.Лхамсүрэн даргатай тусгай групп ирж, хил давах болов. Ингээд Өвөр Монголын Хянган хойд мужийн нутагт ажиллахаар 10 гаруй машин, ДЯЯ-наас Хэнтий аймаг дахь хэлтсийн дарга Ц.Даваажав, Б.Дөрвөлжин, Б.Эршүү, Цэдэнов, японы хэлний орчуулагч Доржсүрэн, Бадамрагчаа, Дорнод Цагдан сэргийлэхийн

сургагч Галкин, 31 дүгээр отрядаас Даваажав, Гомбожав, Г.Намхайдагва миний бие гэсэн бүрэлдэхүүнтэйгээр өглөөний 8 цагт хөдлөн Алтан-Эмээлд нар жаргахын үед очсон юм.

Алтан-Эмээлд байсан Японы цагдаагийн хороог Зөвлөлтийн гвардийн танкийн 111 дүгээр дивизийн анги 08 дугаар сарын 09-ний өглөө Японы офицерууд гимнастик хийж байхад их буугаар буудаж, зэвсгийг нь хураан 18 офицерыг баривчлан цэргүүдийн хамт 17 дугаар армид шилжүүлэн өгсөн байв. Гэтэл өглөө хятад ногоочин ирж 5 япон цэрэг ирж дээрэм хийлээ гэж мэдээлсний дагуу олзлох буюу устгахаар Ц.Даваажаваар ахлуулсан группд Гомбожав, жолооч Д.Сандагсүрэн, өвөрмонгол Билгүүн, Доржсүрэн, Бадамрагчаа, Галкин, барга Дамдинжав, Г.Намхайдагва би томилогдон явсан. Ингээд дайсан хаана бүгж байгааг олохоор Алтан-Эмээлээс 50-иад км зайтай Баруун шар нуга, Зүүн шар нугын хийдүүдээр орж занги, хаван нартай уулзаж, эрж хайх ажлыг зохион байгуулж, Хэрлэн голын хөвөөгөөр байгаа айлуудыг нүүлгэх зэрэг ажлыг хийхийг сануулав.

Хэд хоногийн өмнө япончууд Манжуур хотод Зөвлөлтийн цэргийн эмнэлгийг дайрч, Зөвлөлтийн гарнизоны ангид бут цохигдож, үлдсэн хэсэг нь Далай нуурын загасны үйлдвэрийн ажилчдыг цуглуулан Алтан-Эмээл рүү дайран тэнд олзлогдсон 50 гаруй цэргээ чөлөөлөх бодолтой байсан боловч тэр нь бүтэлгүйтсэн тул ахалж явсан дарга нь гэргий хүүхдээ Далай нуурын ойролцоо алсан тухай мэдээллийг манай тагнуулч группийн удирдагч Ц.Даваажав даргад дамжуулан мэдээлснийг танилцаж, тэдгээр япон цэргүүдийг баривчлахаар явсан юм.

Бид Хэрлэн голд ойртоод дурандав. Гэтэл Гомбожав төмөр малгайнуудын орой голын эргээс булталзахыг түрүүлж харлаа. Мянгаад метрийн зайд толигор талд дайсан ил харагдаж байв. Ц.Даваажав, Гомбожав 2 сум зөөгчийн хамт баруун хойд жигүүрт байрлалаа. Дайснууд 15 орчим байв. Дайснууд ширүүн гал нээж, голын тахиралдсан тохойд байсан Сандагсүрэнгийн жигүүрт ойрхон байгааг дайсан ашиглан голын урсгал дагуу сэлж бидэн лүү ойртлоо. Сандагсүрэн урагшаа мөлхмөгц автомат буу богино галаар буудаж эхлэв. Сандагсүрэнгийн баруун гар шархдаж, боох зүйл байхгүй болохоор нь цамцаа урж боогоод хамт явсан 3 залуугийн нэгэнтэй нь хамт машин руу буцаав. Ц.Даваажав, Гомбосүрэн нар баруун жигүүрээс урагшиллаа.

700-800-аад метрийн зайтай голын цаад хөвөөн дээр дайснууд мөлхөн гарч байгаа харагдаж, Б.Эршүү нэг магазин сумаар галлаж, тусгал үл хүрэв. Харин Ц.Даваажав, Гомбожав хоёр винтов буугаар маш оновчтой ширүүн гал нээж байсан юм. Би пулемётоо холын тусгал дээр тавьж, адууны хомоол шиг харагдаж байгаа дайсан руу галлатал Б.Эршүү харин үлдсэн нэг магазин сумаа тэнгэр өөд галлачхав. Ингээд л гар буутай үлдлээ. Эршүү сум авахаар машин руу явсан юм. Бидэнд дарга гол гатлах тушаал өгөхөд хувцсаа тайлж үертэй гол руу орохоор болов. Дайснуудын сум дууссан учраас автоматаа эвдэж хаясан байв. Бид сэлж чаддаг хүн нэг ч байсангүй гар гараасаа барьцалдан гол гатлав. Ингээд 12-18 цаг хүртэл буудалцаж дайсныг дараад Алтан-Эмээл руу барга Дамдинжаваар холбоо бариулж, нар жаргах үед Алтан-Эмээлээс холбооны 10 гаруй орос цэрэг ирлээ.

Манай групп 08 дугаар сарын 15-нд түр цэргүүдийн ихэнхийг Алтан-Эмээлд үлдээгээд Хайлаарт очиж, маршал Х.Чойбалсангийн гэргий байсан Бортолгойн танил болох Хайлаарын губернаторын бэлэвсэн эхнэр Дондогийн 2 давхар гурван байшинд түр байрласан юм. Тэнд байж байтал Хянган хойд мужийн орлогч дарга Ж.Санжмятав, Цэдээнов бид 3 Солон хошууны Баянхошуу явж, хувьсгалч Соёлжав гэгч хүнийг олж авч ирэх ажилд томилогдоод Зис-5 машинаар явж, Хайлаар голыг гатлах хавирган гүүрэн дээр очтол дайралтад өртөж, тэнд байсан Оросын цэргийн ангийнхан биднийг хамгаалж, дайралтаас аварсан юм. Ингээд Баянхошуу гэдэг газарт хүрч Соёлжавыг авчран Намын Төв Хорооны Нарийн бичгийн дарга Н.Лхамсүрэнд бараалхуулав. Тэд гадаа суун ярилцаж байтал буун дуу гарч Соёлжавын өвдгийг нэвт оноож, Лхамсүрэнгийн суудлыг нэвтэлсэн байв. Би нэг цэргийн хамт Соёлжавыг Зөвлөлтийн гарнизоны эмнэлэгт хүргэх явцад буун дуу тасралтгүй нүргэсээр байсан юм.

Энэ үед Японы хэд хэдэн хороо цэрэг Хайлаарын 3 уулын бэхлэлт төмөр замын туннельд үлдчихээд шөнийн цагаар тулалдан хорлон сүйтгэх ажиллагаа явуулдаг байсан юм. Бид 08 дугаар сарын 18-нд Енгүүн хотыг зорьж, Хянган хотын дарга Эрхэмбаттай уулзан хэлэлцээр ярилцлага хийж, Монгол Улсын бодлогыг танилцуулсан юм. Буцах замдаа Долгорын үр хүүхэд болох Лхамсүрэн, Хандсүрэн, Санжмятав нарыг авч хамтдаа Алтан-Эмээлд ирж тэндээ үлдэх даалгавар авч хоцорсон юм. Энд би Баргын ард түмний санаа бодлыг судалж байсан бөгөөд Баргууд бүгд

Монголын харьяат болно, хэзээ Монгол руу нүүх вэ зөвшөөрөл өгөөч гэж гуйдаг байлаа.

1945 оны 9 дүгээр сарын эхээр олзлогдсон япон эмэгтэйчүүд, хүүхдүүдийг Манжуурын комендантад хүргэн өгөх үүрэг хүлээж, хурандаа Ринчэнтэй хамт явж, хүлээлгэн өгөөд буцаж Алтан-Эмээлд ирж 12 дугаар сар хүртэл байрлаж байгаад буцаж ирсэн юм.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД БАЙШИНТЫН 7 ДУГААР МОРЬТ ДИВИЗИЙН 2 ДУГААР ХОРООНООС ОРОЛЦСОН ТУСГАЙ ТӨЛӨӨЛӨГЧ Я.САНЖЖАВЫН ДУРДАТГАЛ

Хөрвүүлсэн: Д.Отгонцэцэг



Маршал Х.Чойбалсан Өвөр Монголын нутагт

Ядамсүрэнгийн Санжжав нь Хэнтий аймгийн Өмнөдэлгэр сумын нутаг Өлгий гэдэг газар 1917 онд Ядамсүрэнгийн 3 дугаар хүү болон төрсөн. Бага дунд сургууль төгсөж, 1937 онд 20 насандаа цэргийн албанд татагдсан.

1945 оны чөлөөлөх дайнд оролцсон талаар:

1945 онд Японы дарлалаас Хятад, Өвөр Монголыг чөлөөлөх дайнд Монгол-Зөвлөлтийн дайчид оролцсон билээ. Миний бие Байшинтын 7 дугаар морьт дивизийн 2 дугаар хороонд тусгай төлөөлөгч байсан.

Морьт механикжуулсан бүлгийн нэг ангийн чиглэл нь Хятадын Долоннуур, Жэхэ хот руу чиглэсэн бөгөөд энэ чиглэлд дайсны 57674 хүнтэй төрөл бүрийн цэргийн ангиуд байлдааны бэлэн байдалд байгаа гэсэн мэдээтэй байсан. Улсын хилээс Долоннуур хүртэл 450 км, бүгд 700 км газар түргэвчилсэн давшилтаар Японы хойд Хятадын районд байсан зэвсэгийн олон тооны агуулах, төмөр замын зангилаа бүхий чухал хотыг эзлэн авсан юм.

100-300 км үргэлжилсэн элсэн цөл 40 градусын халууныг даван

Маршал Х.Чойбалсан Өвөр Монголын нутагт

туулахад цэрэг дайчдад амаргүй даваа байсан. Долоннуур хотыг чөлөөлөөд цааш 250 км орших Жэхэ хотыг эзлэн авахад түргэн давших шаардлага дээд командаас ирсэн учир Зөвлөлтийн 59 дүгээр морин дивиз, манай 5, 6, 7, 8 дугаар дивизүүд өдөр шөнөгүй давшилтанд ороход ойрын жилүүдэд хүн, амьтан яваагүй баларч гүйцсэн замаар явахад хүн хүч, агт морьд ихээхэн сульдаж байсан боловч алгуурлалгүй дайсны анги салбарыг устгахын тулд урагшилж байсан юм. Долоннууураас Жэхэ хүртэл Хянганы нурууг давахад бартаатай уул хад, шавар намаг, түргэн урсгалтай гол мөрөн үерлэж явахын аргагүй байсан ч энэ бүгдийг бэрхшээл гэж үзээгүй. Бидний замд бууж өгсөн дайсны япон цэргийн хурандаагийн өгүүлсэн нь “Ийм замаар хөсөг тэрэг, морин цэрэг ийм хурдан яваад ирнэ гэж санасангүй” хэмээн өгүүлж байсан нь тодорхой санагдаж байна. Амьд хэл юуны өмнө бидний гараар орж ирдэг болохоор санаанд тодорхой үлдсэн юм. Хойд Хятадын Жэхэ орох замд юмсан. 1945 оны 08 дугаар сарын 18-ны шөнө Хянганы их нуруунд ангиасаа тасарч өвөр замаар орсоноо мэдэж ойролцоо яваа хүнийг сурвалжилвал 7 дугаар дивизийн улс төрийн хэлтсийн дарга Дагжид мөн бидний замаар орчихсон явж байв. Би тэр үед өвөрийн морин жолооч Чимиддорж монгол хэл мэддэг хятад хэлмэрчийн хамт явсан. Ингээд Дагжидтай нийлээд хүн яваагүй буруу замд орсоноо мэдээд ууланд сууж үүр цайлгахаар сууж байтал бидний дэргэдүүр хөх гэрэлтэй гар чийдэн барьсан сүүмэлзсэн олон гэрэл нь юу бол гэж асуухад энэ ууланд бөгсөндөө хөх гэрэл гаргаад явдаг хорхой байдаг юм, тэр нисэж явна гэхэд бид 3 бие биеэ нудралцаж билээ. Хожим хороо

Маршал Х.Чойбалсан Өвөр Монголын нутагт

ангийнхандаа тэр тухай ярихад та хэд зөвхөн зэвүүцэн суусан байна. Бид бараг ангиараа тэр хөх гэрлийн зүг гал нээж эхэлсэн юм гэж бөөн инээдэм болцгоож билээ. Ингээд үүр цайхад бүдэг замаар явсаар нэг жижиг тосгонд ороход Зөвлөлтийн 59 дүгээр морьт дивиз тэр тосгоныг дайраад өнгөрч байх бөгөөд ангиа асуухад огт мэдэхгүй байсан. Гэтэл жанжин Лхагвасүрэн гуай машинтай ирж та хэд чинь яагаад энд явж байдаг билээ, анги чинь хаана явна гэхэд бид төөрсөн учраа хэлэхэд Лхагвасүрэн жанжин танай дивиз буруу замаар явсан шиг байна. Та нар 59 дүгээр дивизийг дагаад яв. Энэ зам бол зөв зам байх ёстой гэж миний газрын зураг дээр тэмдэглэж өгөөд Жэхэ хот хүртэл 50 км орчим үлдээд байсан. Ингээд 59 дүгээр дивизийг дагаад Жэхэ хот орсон юм. 1945 оны 08 дугаар сарын 19-ний өдөр миний хариуцсан 2 дугаар морьт хорооны штабын хамт 34 хүн Жэхэ хотод очих байсан ба бараг 7 хоногийн турш цувралдан ирсэн. 1945 оны 08 дугаар сарын 19-нд Японы цэргийн ихээхэн хэмжээний эсэргүүцэлтэй тулгарсан боловч 08 дугаар сарын 20-нд энэ хотод байсан цэргийн гарнизон зэвсгээ хураалгасан юм. Энэ гарнизоноос 8000 гаруй цэрэг дарга, 9121 винтов буу, 6 их буу, 3 хөнгөн танк, 15 миномёт, 300 гаруй автомашин, зэвсэг хэрэгслийн 420 агуулахын хамт олзлон авсан албан ёсны баримт байдаг юм. Жэхэ хот бол Хянганы нурууны их ууланд байх бөгөөд 1 сая гаруй хүн амтай, Японы олон томоохон цэргийн гарнизон байсан. Ингээд 1945 оны 09 дүгээр сарын 15-наас Зөвлөлтийн 59 дүгээр дивизээс 2 хоногийн хойно манай 5, 6, 7, 8 дугаар дивиз Долоннуур, Баруун Сөнөд, Зүүн Авгын хошуу нутгаар дамжин эх орондоо ирсэн юм.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН 22 ДУГААР МОРЬТ ХОРООНЫ ТӨЛӨӨЛӨГЧ ТӨМӨРИЙН ШАГДАРЫН ДУРДАТГАЛ

Хөрвүүлсэн: Д.Отгонцэцэг

Маршал Х.Чойбалсан Өвөр Монголын нутагт

Төмөрийн Шагдар 1916 онд одоогийн Говь-Алтай аймагт төрсөн. Багш нарыг бэлтгэх сургууль төгссөн.

1934-1938 онд Говь-Алтай аймгийн худалдааны газар, Тайшир сумын захиргааны бичээчээр тус тус ажиллаж байсан.

1938 онд цэрэгт татагдан, ЦЯЯ-ны 7 дугаар дивизийн 20 дугаар хороонд хүнд пулемётын наводчик, Хуягт дивизионд цэрэг жолооч, 1939 оны Халх голын байлдааны үеэр Улаанбаатар хотоос хязгаарт зэвсэг, галт хэрэгсэл зөөгч, Хуягт дивизионд бага, дунд дарга, 1940 оноос ДЯЯ-ны цэргийн анги салбарууд хариуцсан Цэргийн тусгай хэлтэст төлөөлөгч, Матадын 8 дугаар дивизийн 22 дугаар морьт хороог хариуцсан төлөөлөгчөөр ажиллаж байжээ.

Чөлөөлөх дайнд Матадын 8 дугаар дивизийн 22 дугаар морьт хороог хариуцсан төлөөлөгчийн хувьд ангийнхаа хамт чөлөөлөх дайнд явсан. Замд тохиолдсон Японы хилийн харуул анги бэхлэлтийг устгаж яваад 1945 оны 08 дугаар сарын 19-нд фронтын дээд командлалаас дивизийн штабт Японы цэрэг армийг буулган авах тушаал өгсөнд дивизийн дарга Одсүрэн 22 дугаар морьт хороонд тушаал өгч, манай

ДЯЯ-ны сайд Б.Шагдаржав Өвөр Монголын ноёдын хамт

хорооны араас 34 дүгээр хороог явуулан ард нь дивизийн штаб орж, уг хотыг эзлэн авахаар давшин ороход хэсэг цагаан туг барьсан хятадууд угтан ирээд япон цэргүүд урд даваагаар даваад явчихсан гэж хорооны удирдлагуудад хэлсэнд хороон дарга хөөж устгах шийдвэр гарган хөдлөхөд төлөөлөгч Шагдар би хорооны орлогч Дамжингийн хамт үлдэж тэр хотод шалгалт хийж, япон цэргүүд үнэхээр явсан эсэхийг мэдэхээр болж хоцроод цэргийн байраар ороход телефон нь холбоотой орхиж, дэргэд япон хурандаагийн хувцас байсан, мөн дэргэдэх тасалгаанд нь буу зэвсэг, хэсэг зүйл ил тавьсан, цэргийн байрны бүх зүйл нь үнэхээр явсан бололтой байхаар нь телефон аппаратыг таслаад ангийнхаа араас явахаар болж, нэг шавар хэрэмний өнцгөөр гартал цаана нь 7 япон офицер зогсож байсан ба харалдаа цаад уулын энгэрээр япон цэргүүд үргэлжлэн нарлаж харагдсанд би морь баригч хоёр цэргээ автомат буугаа бэлэн болгож хамт очоод хэрэв аль нэг нь буудвал гал нээж 7 офицерыг устгаад хоёулаа тариан дундуур тарж зугтан дивизид холбоо барь гэдэг үүрэг өгч өөрөө түрүүлэн нөхдөө дагуулан япон офицерууд дээр очиж ёслоод гар барихаар сарвайнгуутаа зүүж явсан модон хуйт маузер бууг сугалж аваад харахад хорооны орлогч дарга Дамжин ч мөн офицерын бууг авч харагдсан, тэгээд орлогчийн морь баригч хятад хэлтэй цэргээр тэдэнд манай толгой хаалтын хэдхэн цэрэг тэр явж өнгөрлөө гэж хороогоо заагаад одоо араас манай гол хүч ирж яваа, та нар Зөвлөлтийн улаан арми ба Монгол цэргийн бүслэлтэд орсон байна, тэднийг ирэхээс өмнө бууж өгч зэвсгээ хураалгавал та нарын зэвсгийг чинь хурааж аваад суллан явуулна, эс бууж

Маршал Х.Чойбалсан, жанжин С.Лхагвасүрэн нар Хятадын цагаан хэрэм дээр

өгвөл зэвсгийн хүчээр устгах болно гэж шаардахад бүрээчээ дуудаад жагсах бүрээ үлээлгэсэнд цэргүүдийн нэг хэсэг нь босож жагсаад хагас нь босохгүй байсан. Гэтэл манай араас ирж яваа 34 дүгээр хороог гарч ирэхийг нь хараад 7 офицерын нэг нь цэргүүд рүүгээ орилоод гүйгээд явсанд манай хэлмэрч цэрэг маань одоо түргэн босож ирэхгүй бол болохоо байлаа гэж хашхирч явна гэсэн тэгтэл цөм босож голын цаад талд явж ирэхэд нь буу зэвсгээ тэндээ орхиод голын наад талд гарч жагс гэж хэлүүлсэнд тэр ёсоор жагсахад нь бид офицер цэрэг зэвсгийн тоог авч байтал дивизийн штаб ирж, дивизийн дарга Одсүрэн, тусгай тасгийн дарга Загд нарт байлдааны тушаал биелүүлж Японы 172 цэрэг, офицер, 8 миномёт, 6 пулемёт, 160 винтов ачаа хөсгийг буулган авснаа илтгээд бүх зүйлийг хүлээлгэн өгөхөд дивизийн дарга Одсүрэн бидэнд баяр хүргэж, “Та нар ангийнхаа хойноос очиж, дивиз багтахаар зайтай газар олж буугаад амарч бай араас чинь дивизийн бүх ангиуд очно, тэгээд фронтын тушаал хүлээж аваад цааш давших болно” гэлээ. Тэгээд бид ангийнхаа хойноос очиж болсон зүйлээ хорооны дарга Балдандоржид ярихад зөвлөх нь хорооны дарга та бид 2 бүхэл бүтэн цэргийн анги хориглосон байхад үзэхгүй өнгөрөөд муу байна гээд өөрсдийгөө зэмлэж байсан. Тэгээд амарч хоноод хойд Хятадын нийслэл Жэхэ хотыг эзлэн авахаар 08 дугаар сарын 19-нд давшин ороход Зөвлөлтийн улаан армийн танкийн анги 18-нд эзлэн авсан байв. Тэгээд манай 8 дугаар дивиз Жэхээгээс 30 км-ийн зайтай Лүнфен

Маршал Х.Чойбалсан Өвөр Монгол иргэдийн хамт

хотод байрлан Японы зэвсгийн складууд минийн үйлдвэр, цахилгаан станцыг харж хамгаалан байгаад Хятадын 8 дугаар армийг ирэхээр нь хүлээлгэн өгсөн. Биднийг Лүнфенд байхад маршал Чойбалсан, армийн генерал Плиев нар ирж амжилттай давшилт хийж ялалт байгуулсныг Зөвлөлтийн Засгийн газар болон Сталин баяр хүргэснийг уламжлан баяр хүргэж байсан.

Тэгээд бид эх орондоо буцаж Хэнтий аймагт ирж байхад Намын Төв Хороо, Засгийн газрын төлөөлөгчөөр Янжмаа гуай ирж баяр хүргэж байсан. Тэгээд цэргийн алба хаах хугацаа дууссан ба бага дарга цэргүүдийг халаад 8 дугаар дивизийг тарааж, уул дивизийн аль тэргүүний сайн гэсэн офицер, бага дарга, цэргүүдээр 19 дүгээр хороо гэж шинэ хороог байгуулаад бусад хүмүүсийг өөр дивиз, хороонд шилжүүлсэн тэр шинэ хороог хариуцсан төлөөлөгчөөр Шагдар намайг томилсонд би тэр хорооны бүх бичиг баримтыг цэгцэлж, шинэ ирсэн хүмүүстэйгээ танилцаж байтал 1946 онд 25 жилийн ойн баярт оролцоод буцаж хороотойгоо Байшинтын 7 дугаар дивизид очиж байрлах газраа засаж байтал Шагдар намайг Хэнтий аймагт шинэ байгуулагдсан Улсын баатар Нянтайсүрэн даргатай механикжсан танкийн бригадад Гомбосүрэн даргатай их бууны тусгай хорооны дэргэдэх тусгай ангид ахлах төлөөлөгчөөр дэвшүүлэн томилсон юм.

ЧӨЛӨӨЛӨХ ДАЙНД ОРОЛЦСОН 24 ДҮГЭЭР ОТРЯДЫН ТУСГАЙ ГРУППИЙН ОРЛОГЧ ДАРГА Х.ХАСБАЗАРЫН ДУРДАТГАЛ

Хөрвүүлсэн: Д.Отгонцэцэг

Өвөр Монголын ноёд түшмэдийн хамт

Дэлхийн II дайны голомт Японы империалистуудыг бут ниргэх явдал Ази, дорно дахины амин чухал ажил болж байсан 1939 оны ариун дайнд оролцож явсан ажиллагаа санаанд бууна.

1939 оны байлдаанд чухал үүрэг гүйцэтгэж байсан одон тэмдэгт застав төрүүлсэн Халх гол дахь хурандаа П.Чогдон даргатай хилийн 24-р отрядын оруулсан гавъяа багагүй бий. Байлдааны үед зүүн хязгаар ялангуяа Халх голын орчмоор Японы империалистууд манай улсын дархан хил хязгаарыг зөрчих, будлиантуулах асуудал бүр ч ширүүн болж, тагнуул төлөөлөгчөө байнга тавьж, хилийг зөрчих явдал олонтоо болж хил хязгаарыг улам түгшүүртэй болгосноор барахгүй Монголын хил рүү их буугаар буудсан тал ч гарч байлаа. Удалгүй 1945 оны 8 дугаар сарын 9-нд ЗХУ-ын Засгийн газраас дорнод зүгт дайны голомт болж байгаа Японтой дайн зарлаж Халх голын районоор Зөвлөлтийн явган дивиз, морин хороо, танкийн бригад, их бууны хороо, нисэх онгоцны групп зэрэг хүчтэйгээр манай улсын хилийг 9-ны шөнө давахаар манай сумангийн хамгаалж байсан районоор давшилтаа эхлэхээр ирж байрлалаа. Бид хилээ хамгаалсаар л байлаа. Гэтэл эдгээр Зөвлөлтийн

ангиудын удирдлагаас үүрэг өгсөн. Үүнд: дайсны ямар хүч байгааг тагнуул хийж холбоо барьж туслалц гэсэн ёсоор би хэдэн цэргийн хамт үүрэг гүйцэтгэн Японы 3 застав цэргийн байрлал, хүч хэрэгслийг илрүүлэн илтгэсэн билээ.

Энэ үед манай суман дарга нь ахлах дэслэгч Хархүү, орлогч нь би өөрөө, туслах ахлах дэслэгч Дамба, эмч дэслэгч Дашцэрэн нар байсан юм. Удалгүй 8 сарын 10-нд БНМАУ Японтой дайн зарлаж манай хилийн 24 дүгээр отряд дайсны ар талд тагнуул туршуул хийж, фронтын зай завсраар үлдэн хоцорсон дайсны үлдэгдлийг устгах үүрэг авч байлдаж байгаа Зөвлөлт-Монголын армиудын бэлтгэл хүч резерв болж, 8 дугаар сарын 10-ны шөнө газар тэнгэр нийлэм ширүүн усан бороноор 2 тусгай отряд болж, нэг отрядыг Халуун рашааны чиглэлд группийн даргаар улс төрийн орлогч Балжинням даргалан, нөгөө отрядыг хурандаа Чогдон удирдаж, энэ шөнө хил давж үүрэг гүйцэтгэхээр замд гарлаа. Миний бие Чогдонгийн отрядад сумангийн орлогчоор ажилласан юм. Бид 120 хүнтэй хил давсан юм.

Манай отряд хүн бүр хоёр морьтой бүрэн зэвсэгтэйгээ гарч, Баргын нутаг хошуу сүмийг эзлэн тэнд их амралт хийж норсон хувцсаа хатааж, дараагийн гүйцэтгэх үүргээ судлаж Мүгдэнгийн чиглэлд ажиллах хайгуул, тагнуул, туршуул хийж, улмаар отрядын штаб тэнд байрлаж бид тал тал тийшээ үүрэг гүйцэтгэх боллоо. Үүнд: манай анги нь Барга, Солон, Хөлөн буйр зэрэг Өвөр Монгол барга хошуудын нутаг, Хайлаарын орчимд ажиллаж дайсны ард үлдэж хоцорсон, бүгсэн нэлээд дайсныг устган 250 гаруй цэрэг, офицерыг барьсны дотор Октябрийн хувьсгалаас урвасан цагаантны үлдэгдэл атаман Семёновыг илрүүлж баривчилсан бөгөөд хүнд хөнгөн пулемёт танк эсэргүүцэх буу зэрэг нэлээд зэвсэг, 2 сая гаруй сум, эмнэлгийн газар 1, худалдаа дэлгүүр 2-ыг олзлон авсан ба манай ангиас байлдагч Бүргэдийн Шарав, офицер Содномдаржаа, Гүр, Хархүү, Норов, Сэрээтэр, Чулуунбаатар зэрэг олон офицер, түрүүч, цэргүүд онц байлдсан хийгээд бид дайны явцад ар талд ЗХУ, БНМАУ-ын нэр хүнд, дайн явуулж буй учир бодлого, Японоос Өвөр Монголын ард түмний талаар явуулж байсан бодлого, түүний хор уршиг, байлдаж яваа Зөвлөлт-Монголын армиудад туслах, дайсныг ул мөргүй устгахад туслах зэрэгт нам, улс төрийн ажлыг чиглүүлж байсан юм. Энэ байлдаанд миний оруулсан хувь нэмэр гэвэл отрядын дарга Чогдонгийн тушаалаар Баргын хошууны 2 ноёныг урин авчирч манай ангийг үүргээ биелүүлж дуустал агт морьд, хоол хүнсээр туслах аман хэлэлцээ хийхэд оролцсон ба нутгийн ард түмний тусламжтайгаар Хайлаар хотын онцгой хэлтэст удирдах ажил хийж байгаад дайн эхлэхийн хамтаар буу зэвсэг бүх зүйлээ хаданд хийж бүгж байсан Хайлаар хот дахь

БНМАУ-ын Баатар П.Чогдон

Японы онцгой хэлтсийн даргын туслагч Барга офицер, гавьяаны II одонтой буриад Жигжидийг баривчилсан, мөн дайны жилүүдэд Японы даалгавраар манай эх оронд 7 удаа тагнуул хийж явсан барга Агдаагийн Дамдинсүрэнг, Баатар, Содов гэдэг 3 тагнуулыг илрүүлэн баривчилсан. Мөн манай дотоодоос оргосон Цэрэндаш гэгчийг баривчилсан зэрэг үүрэг гүйцэтгэсэн бөгөөд Барга, Солон хошуу, Улаан харганаагийн буриадуудын дунд МАХН-ын ба БНМАУ-ын Засгийн газраас гаргасан уриа лоозон, Маршал Х.Чойбалсангийн зураг бүхий ухуулгыг 2 хошууны айл өрх буюу 8000 шахам хүнд тараан уншиж ухуулах үүргийг бага дарга Барамсайн хамтаар гүйцэтгэж явсан ба манай сумангийн бүрэлдэхүүний нэлээд хэсэг нь оролцсон тул цэргүүдийн дунд яаралтай хурал цуглаан хийх, нам эвлэлд гишүүн элсүүлэх, болж буй цагийн байдал, дайсны үйл ажиллагаа ЗХУ-ын ба өөрийн армийн ялалтуудаас яриа таниулга зохиож байсан. Барагцаалбал 5 хүний дунд нэг ухуулагч томилон ажиллуулж байсан. Үүний үр дунд манай талд ямар ч хохирол учраагүй. Харин ч Өвөр Монголын барга, Солон хошууны олон тооны Өвөр Монгол залуу гэр бүл хүмүүс манай талд орж ирсэн учир Чойбалсан аймгийн Хөлөн буйр сум болгож байгуулсан буюу залуучуудыг нь сургуульд оруулах, үйлдвэр фабрикт ажиллуулах зэргээр ажил зохиосны дүнд нь манайд ажиллах хүчний дутмаг нөхцөлд тус хүргэсэн нь мэдээж билээ. Бидний гүйцэтгэсэн үүргийг Зөвлөлт-Монголын Засгийн газраас өндөр үнэлэлт өгч олон тооны офицер, цэргүүдийг засгийн дээд шагналаар шагнасан юм.

Миний бие энэ байлдаанд гавъяа байгуулсан гэж Байлдааны медаль, Зөвлөлт-Монголын “Бид ялав” медалиар шагнагдсан юм.

1945 оны 12-р сарын тэр нэгэн өдрийг эргэж санахад арга буюу хүнд нөхцөлийн дунд дасаж танилцсан отрядын дарга Чогдон, штабын дарга Шагдаржав, улс төрийн орлогч Балжинням, намын товчооны дарга Төмөрбаатар, эвлэлийн товчооны дарга Чулуунбаатар, аж ахуйн дарга Лувсанжамц, байлдагч Шарав нарын олон хүний мөнхийн дүр хоногшино. Бид цөм цуглавал хэдэн хоног өнжин хууч дэлгэх биз.

20 ДУГААР ОТРЯДЫН ТУСГАЙ АНГИЙН ДАРГА УНДРАХ ОВОГТОЙ ХУВДАЙН ДУРДАТГАЛ

Хөрвүүлсэн: Д.Отгонцэцэг

Чөлөөлөгдсөн нутагт

У.Хувдай 1918 онд одоогийн Завхан аймгийн Дөрвөлжин сумын нутаг Өвөр Баян-Айраг хэмээх газар төрсөн. 1927 онд Цэцэн Сартуул уулын хошууны сургууль, 1931 онд Завхан аймгийн төвд байсан Мал аж ахуйн сургууль, 1936 онд Завхан аймгийн Завхан мандал суманд галч, бичээч, Эвлэлийн үүрийн даргаар ажилласан. 1937 оны 8 дугаар сарын 15-нд цэргийн албанд татагдан ирж, Улаанхуаранд байсан морьт дивизид цэрэг бичээч түгээгчийн үүрэг гүйцэтгэж байтал 1939 оны 4-р сарын 28-нд маршалын тусгай тушаалаар Дотоод явдлын яамны 4-р хэлтэст шилжин ирж, Улаанхуаранд байсан морьт дивизид цэрэг бичээч, түгээгчийн үүрэг гүйцэтгэж байтал 1939 оны 4-р сарын 28-нд маршалын тусгай тушаалаар Дотоод явдлын яамны 4 дүгээр хэлтэст шилжин ирж, жинхэнэ төлөөлөгчөөр томилогдон хотын жижиг анги Цагаанхуаранд байрлаж байсан Халх голын фронтын арын баазуудыг хариуцан

ажиллаж байсан юм.

Үүнд: Халх голын фронтын шинээр ирсэн зэвсэг, техник цэргийн хүчээр хангах ба фронтоос эвдэрч ирсэн зэвсэг техникийг засварлуулж фронтод буцаан явуулах, олзлогдон ирсэн дайсны цэргүүдийг асууж шинэ мэдээнүүдийг илрүүлэн олж цэргийн командлалд өгөх зэргээр ажиллаж байгаад дайн дууссаны дараа дайны хохирлыг гаргах комисст ажилласан ба 1940 оны эхээр Японтой хэлэлцээ хийх цэргийн комиссар явсан. Улсын баатар Чогдон, Дорж, дэд хурандаа Данзан нарын авч явах материалыг гаргаж өгөх зэргээр ажилласан юм.

Намайг ингэж ажиллаж байхад 1939 оны 7 дугаар сарын 19-нд Цагдан сэргийлэхийн улаан буланд маршал Х.Чойбалсан Дотоод явдлын яаманд шинээр ирсэн бүх хүмүүсийг цуглуулж, нам, улс армийн дотроос та нарыг сонгон авч чухал байгууллагад цаг үеийн хүнд нөхцөлд ажиллуулж байна. Та нар улс эх орондоо үнэнч шударга сайн ажиллах хэрэгтэй. Ийм итгэлийг нам засаг чинь өгч байна гэж хэлсэн билээ. 1939 оны 7 дугаар сарын сүүлчээр нэгэн сайн өдөр 1 дүгээр дивизийн 1 дүгээр хороонд ахлах дэслэгч цолтой сумангийн дарга байгаад фронтоос оргон ирсэн Жамъян гэгчийг асууж суутал гэнэт маршал тэргүүтэй олон хүн орж ирээд Жамъянтай ярилцаад дараа нь надад чухам эх орноо хамгаалах явдлаас татгалзсан ийм үзэл яагаад орох болсон, өөр хэн хэн оргосон, дайсанд хэн хэн очсон зэргийг сайн асууж илэрсэн зүйлээр бич гэж үүрэг өгснийг би даруй биелүүлж байсан билээ. 1940 оны хавар намайг Сулинхээрийн 34 дүгээр хорооны тусгай төлөөлөгчөөр томилж, мөн оны 7 дугаар сард ангийнхаа хамт Матадын 8 дугаар дивизид шилжүүлсэн. Тэнд очоод ажиллаж байтал мөн оны 10 дугаар сард хилийн отрядуудын дэргэд тусгай анги анх байгуулахад Замын-Үүдийн 12 дугаар отрядын тусгай ангийн даргаар очиж 1944 оны 2 дугаар сар хүртэл улсын хил хамгаалах үүрэг гүйцэтгэсэн. Энэ хугацаанд Японы империалистууд улсын хил хязгаар нэвтрэн тагнуул хийх янз бүрийн ухуулга хаяж, хилчдийг эх орноос нь урвуулах зэвсэгт өдөөн хатгалга хийж байсан билээ.

1944 оны 8 дугаар сард 3 дугаар заставын хил одоогийн Замын-Үүдийн төмөр замын станц байгаа газраар Баруун Сөнөдийн Япон тагнуулын газрын дарга 3 хүний хамт ачааны машин дүүрэн бичиг баримттай явж байгаад хилийн манаатай буудалцаж баригдсан учир Японоос явган морь, машинтай хүнд хөнгөн пулемёт, танк эсэргүүцэх 14 буугаар зэвсэглэсэн 1000 гаруй хүний хүчээр 7 хоногийн турш манай хил дээр ирж баригдсан хүмүүсээ нэхэмжлэн будлиан гаргаж байхад отрядын комиссар Цэрэнпунпаг байлдан, тасгийн дарга Гиваа, бид

гурав ээлжийн ахлах манаагаар томилогдон Зөвлөлтийн армитай хамт эх орноо хамгаалах үүрэг гүйцэтгэсэн юм.

1940 оны 12 дугаар сард Улсын маршал Х.Чойбалсан МАХН-ын Төв Хорооны дарга Ю.Цэдэнбал, Улсын Бага Хурлын Тэргүүлэгчдийн дарга Бумцэнд нар улсын хилээр явж байхдаа миний ажилтай танилцаж хил давж Хятадын худалдаачдыг хэссэн сумангийн дарга Гомбосүрэн, заставын дарга Зурнай нарын тухай танилцаад эдгээр хүмүүсийг арга хэмжээ авах ба хойшид улсын хилийг нэг ч хүн сэм давуулахгүй байх үүрэг өгсөн юм.

Намайг 1944 оны 11-р сард Чоно голын 20 дугаар отрядын Тусгай ангийн даргаар шилжүүлсэн учир тэнд ажиллаж байгаад 1945 оны 8 дугаар сарын 10-нд империалист японы эсрэг явуулсан чөлөөлөх дайнд 20 дугаар отрядын 2 дугаар группийн гүйцэтгэх ажил эрхэлсэн орлогчоор группийн дарга Нанзадын удирдлагаар Өвөр Монголын Зүүн Хуучдын хошуугаар орж 12 дугаар сарын 16-нд улсын хил хаах хүртэл ажилласан билээ. Үүнд гүйцэтгэсэн үүрэг:

1. Өвөр Монголын түшмэдийн хурлын дарга, цэргийн жанжин штабын дарга хошууч генерал японы наран, саран одонт Лувсансүнжүүванчиг гэгч ордоо хаяж зэвсэгтэйгээр элсэнд нуугдаж байсныг илрүүлэн группийн дарга Нанзад, сумангийн орлогч дарга Лувсаншарав нарын хамт очиж олзлон авч Бандид гэгээний хийд дээр байрлаж байсан манай түр Засгийн газрын төлөөлөгчдөд мэдэгдэхэд Лувсансүнжүүванчигийг биеэрээ хүргэж ирэх үүргийг надад Дотоод явдлын яамны орлогч сайд хошууч генерал Дүйнхэржав өгсөн учир хоёр цэргийн хамт биечлэн хүргэж өгсөн юм.

2. Өвөр Монголын Баруун Үзэмчин хошуунд төвлөж байсан Япон тагнуулын монгол дарга Өлзийбаяр гэгч зэвсэг бүхий 7 хүний хамт оргосныг 1 дүгээр групп мөрдөн хөөж, Ар Хянганы нуруунд гаргаад алдсаныг мөрдөн хөөж баривчлах үүргийг тус яамны сайд хошууч генерал Шагдаржаваас надад өгснийг би бага дарга Гэндэнванчиг, цэрэг Шагдар, Эмээл нарын 5 цэргийн хамт 13 хоног мориор хөөж, Хянган уулын баруугаар урагш давуулан хөөсөөр Хятадын Шар мөрний хойт элсэнд учирч буудалцан Өлзийбаяр өөрийгөө алсан ба Дорж гэгчийг бид устгаад 5 хүнийг олзлон авчирсан юм.

3. Хишигтийн хошууны харъяат Токио хотын тагнуулын дээд сургууль төгсөж ирээд манай улсын хилийг 3 удаа нэвтрэн тагнуул хийсэн нэг залууг амьд баригдахгүй өөрийгөө хорлоно гэж 7 сумтай маузер буутай, морьтой Хянган ууланд нуугдан байсныг илрүүлэн 8 хоног ухуулсан боловч хүлээж аваагүй учир эцэг эхийг дүүтэй нь очуулан салах ёс

гүйцэтгэх команд би өөрөө өгч бага дарга Гэндэнванчигийг араас нь модон дундуур явуулж эцэг ах дүү нартайгаа салах ёс гүйцэтгэх завсар Гэндэнванчиг араас нь барьж чадсанаар зэвсэг бүхий 6 тагнуулчдыг баривчилсан юм.

4. Японоос бэлтгэж Монгол-Зөвлөлтийн эсрэг явуулж байсан 62 тагнуулчдыг олж илрүүлэн баривчилсан ба Зөвлөлт-Монголын армид цохигдон зэвсэгтэйгээ нуугдсан Өвөр Монголын 100 цэргийн албан хаагчийг илрүүлэн олзолсон юм.

5. Бандид гэгээний хийдэд байсан түр засгийн газрын тэргүүн ерөнхий сайдын орлогч Ламзав тус яамны орлогч сайд Дүйнхэржав нарын ам тушаалаар 9 дүгээр сарын сүүлчээр монголын армийг буцахад уналгын морь 2000, тэмээ 1000, үхэр 1000-ыг Баруун, Зүүн Хуучид, Баруун Үзэмчин хошуудаас 5 хоногт гаргуулан өгөх даалгавар надад өгснийг группийн дарга Шагдаржав, Нанзад, Самдан нарын туслалцаатайгаар хугацаанд нь гаргуулан өгч чадсан юм.

Намайг чөлөөлөх дайнд үүргээ сайн биелүүлсэн гэж 1946 онд улсаас байлдааны гавъяаны улаан тугийн одонгоор шагнасан ба Байшинтын Тусгай тасгийн даргаар дэвшүүлэн хошууч цолоор шагнасан юм.

“ТУСГААР ТОГТНОЛ”

Үндэсний аюулгүй байдал, тагнуул судлалын эрдэм шинжилгээ, судалгаа, онол, аргазүйн сэтгүүл

СЭТГҮҮЛИЙН ЗӨВЛӨЛ

Эрхлэгч:
Г.Батжаргал

Нарийн бичгийн дарга:
Д.Авирмэд доктор, дэд профессор

Гишүүд:
Д.Тунгалаг доктор, профессор
Д.Мөнх-Очир
Ц.Дашдэндэв

EDITORIAL BOARD

Editor in Chief:
Г.Батжаргал

Secretary:
D.Avirmed (Ph.D), assoc.prof

Members:
D.Tungalag (Ph.D), prof
D.Munkh-Ochir
Ts.Dashdendev

Эрхлэн гаргасан:
Үндэсний тагнуулын академи

Тус сэтгүүлд нийтлэгдсэн материалын агуулга, тоо баримтын бодит үнэн, эх сурвалжаа заасан байдлыг зохиогч, нийтлүүлэгч өөрөө хариуцах бөгөөд үзэл бодол, үнэлэлт дүгнэлт нь Сэтгүүлийн зөвлөлийн байр суурийг илэрхийлэхгүй.

Тус сэтгүүлд материал нийтлүүлэх буюу санал, хүсэлт гаргах бол дараах хаягаар хандана уу.

Сэтгүүлийн хаяг:
Монгол Улс, Улаанбаатар хот, Сүхбаатар дүүрэг 10-р хороо, Ногоон нуурын гудамж

Утас: 92263508
E-mail: nat_int_academy@gia.gov.mn

Улсын бүртгэлийн дугаар: № 390